



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: **ХААИС, МАГИСТР ДОКТОРЫН СУРГУУЛЬ**

Хөтөлбөрийн нэр: **УРГАМАЛ ХАМГААЛАЛ, ХОРИО ЦЭЭРИЙН
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ**

Индекс: **E08110104**

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Оюунцэцэг (Ph.D)

Гишүүд: Н. Цагаанцоож (Ph.D)

..... Я.Гэрэлчулуун (Ph.D)

Улаанбаатар хот

2021 он

Агуулга

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга

Шалгуур 2: Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Шалгуур 3: Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт

Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем

Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ХААИС, Магистр, докторын сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт, үнэлгээ	
Индекс	E08110104	
Шинжээчид	<p>Ахлагч:</p> <ol style="list-style-type: none"> 1. Б.Оюунцэцэг. МУИС-ийн БУС-ийн Биологийн тэнхимийн багш, доктор, дэд профессор <p>Шинжээч:</p> <ol style="list-style-type: none"> 2. Н.Цагаанцоож. ШУА-Газарзүй, гео-экологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор 3. Я.Гэрэлчулуун. МУБИС-ийн Ургамлын судалгаа, сургалт арга зүйн төвийн эрхлэгч, доктор 	
БМИҮЗ-ийн зохицуулагч	Магадлан итгэмжлэл харицсан шинжээч Б.Оюунчимэг	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд
		/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021.05.18	Шинжээчийн багтай гэрээ байгуулах
	2021.05.19	Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хүлээн авах
	2021.05.25	Өөрийн үнэлгээний тайланг уншиж судлан дүгнэлт хийх, тодруулах асуудал бүхий урьдчилсан үнэлгээний тайланг зохицуулагчид илгээх
	2021.05.27-28	Шинжээчийн баг сургууль дээр болон цахимаар ажиллах
	2021.06.08	Шинжээчийн багийн нэгдсэн дүгнэлт, тайланг илгээх.
Шалгуур шаардлага /журам/	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 06 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур, шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Монгол орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжил, байгаль орчны хамгаалал, хүн амын хүнсний аюулгүй байдал зэрэг үндэсний болоод дэлхий нийтийн чиг хандалгад нийцсэн ногоон хөгжлийн язгуур ухагдахуун, мэдлэгт суурилсан инновацыг газар тариалангийн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, судалгааны ажлын үр өгөөжийг үйлдвэрлэлд ашиглах, шинжлэх ухаанд үндэслэсэн байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх, ургамал, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний чанар, биологи, биологийн бус гаралтай эрсдэлд хяналт тавих, сэргийлэх, ургамлын эрүүл ахуйн дэглэмийг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэгч нь ургамал хамгаалал, ургамлын хорио цээрийн салбарт бэлтгэгдэж буй магистрын зэрэгтэй мэргэжилтнүүд юм. Монгол улсад энэ салбарт ажиллах мэдлэг, ур чадвартай мэргэжилтнүүд ямагт эрэлт хэрэгцээтэй байсаар ирсэн. Магистрын зэрэг олгох “Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт, үнэлгээ” хөтөлбөр нь олон улсын болон үндэсний магистрын зэрэг олгодог хөтөлбөрийг баримжаалан хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Онол аргагүйн өндөр түвшний мэдлэгтэй, ургамал хамгаалал болон бусад хавсрага шинжлэх ухааны судалгааны аргуудыг эзэмшсэн, туршилт судалгааны ажил бие даан гүйцэтгэж, үр дүнг гаргах, чадвартай газар тариалан, ургамал хамгаалал, ургамлын хорио цээрийн салбарын дотоод, гадаад хөдөлмөрийн зах зээлд хөрвөх чадамжтай мэргэшсэн боловсон хүчин бэлтгэхэд оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг гүйцэтгэнэ.

Нэгдүгээр зорилт. Ургамал хамгааллын шинжлэх ухааны сэдвийн хүрээнд судалгааны аргагүй болон шинжлэх ухааны суурь зарчмын талаар өргөн хүрээний мэдлэг олгох

Хоёрдугаар зорилт. Хөдөө аж ахуй байгалийн ухааны ололт амжилтыг ургамал хамгааллын салбарт хэрэглэх мэдлэг, ур чадвар бүхий мэргэжилтнүүдийг бэлтгэх

Гуравдугаар зорилт. Ургамал хамгаалал, хорио цээрийн салбарт ажиллах нарийн мэргэшсэн судлаач, мэргэжилтнүүдийг бэлтгэх

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг бүрэн хэрэгжүүлэх үүднээс төгсөгчдийн мэдлэг, чадвар, дадлыг төрөл бүрийн таримал ургамал, бэлчээр, ойд тархсан хөнөөлт организмыг (ургамлын өвчин, хөнөөлт шавьж, хачиг, мэрэгчид, хог ургамал бусад) таних, тодорхойлох, хөнөөл, эрсдлийн түвшнээр ангилан тэмцэх аргыг оновчтой сонгох, зохион байгуулах үндсэн арга, техникт суралцаж, асуудалд шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах туршлага, мэдлэг, ур чадвар бүхий мэргэжилтнүүдийг бэлтгэхэд чиглэсэн байнгын үйл ажиллагааг гүйцэтгэж, хөтөлбөрийг тогтмол сайжруулан ажиллаж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн боловсруулалт

Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна.

Хөтөлбөрийн зорилго зорилт оюутанд олгох мэдлэг чадварыг үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу нийгэм хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тогтоох боломжийг бүрдүүлэн ажилласан байна.

Илрэл нотолгоо:

- БСШУС-ын сайдын баталсан магистрын хөтөлбөрийн нийтлэг шаардлага
- ХААИС-ийн алсын хараа эрхэм зорилго, баримтлах бодлого, Дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (IV зорилт), Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Боловсрол-2030 Инчёны тунхаг
- Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 2018/282 тогтоол), Үр дүнд суурилсан боловсролыг хөтөлбөр, Дээд боловсролын шинэчлэлийн зураглал (Roadmap 2010-2021) зэрэг бичиг баримт үндсэн шаардлага, жишиг, стандарт.
- Хөтөлбөрийн хорооны журам.
- Гадаадын их, дээд сургуулиудын ургамал хамгааллын мэргэжлийн магистрын хөтөлбөртэй хийсэн харьцуулалт (ОХУ-ын К.А. Тимерязевын академи, БНХУ-ын Зэйжангийн Их сургууль (Zhejiang University), ХБНГУ-ын Гёотенгийн Их сургууль (Goeting University), Итали улсын Падовагийн Их сургууль (the University of Padova), БНЭУ-ын Рангагийн ХААИС, (Erasmus+ Programme Capacity-Buildings Project in the field of Higher Education (E+CBHE'))
- Дотоодын их, дээд сургуулиудын харьцуулалт (МУИС, ХААИС)

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр төгсөгч мэргэжилтний хэрэгцээ, шаардлагын дүн шинжилгээг STEEP аргаар хийж, хүчин зүйлүүдийг тодорхойлсон байна.
- Нийт хичээлийн 33 багц цагтай, 10 багц цаг нь мэргэжлийн суурь, 12 багц цаг нь сонгон мэргэшүүлэх хичээл эзэлж, судалгааны семинар нь 4 багц цаг, магистрын ажил нь 7 багц цаг байна.
- Гадаадын сургуулиудтай харьцуулсны үр дүнд мэргэжлийн суурь хичээл 6 кр, 10 кр болгож 4 кр буюу 18 хувиар нэмэгдүүлж хичээлийг төлөвлөгөөнд шинээр оруулсан юм.
- Магистрын сургалтын үйл явц нь чөлөөт сонголттой. Монгол улсын ХАА-н салбарыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэх, ургамал хамгаалалын салбарын хөгжлийг шинжлэх ухааны баримжаатай авч явах, ижил мэргэжлээр олон улсад хөрвөх чадвартай, олон улсын түвшинд зөвшөөрөгдөх мэргэжилтэн бэлтгэхэд сургалтын үйл ажиллагаагаа удирдан явуулдаг.
- Багш төвтэй сургалтын арга зүйгээс зориулалттын орчин, туршилт нөхцөлд, жишээнд гэх зэрэг арга зүй рүү, мэдлэг, ур чадвар олгоходоо оюутны судалгааны арга зүй боловсруулах замаар мэдлэгээ сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, OneMis программыг нэвтрүүлснээр зайн сургалтыг явуулах, зайн сургалтыг явуулах боломжийг бүрдүүлж буй давуу талууд байна.
- ХАА-д ажиллагсадын тоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгаа бөгөөд үүнээс магистр буюу түүнээс дээш зэрэгтэй боловсон хүчний тоог нэмэгдүүлснээр цаашид бүтээлч, өндөр ур чадвар бүхий ажиллах боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, улмаар төрөөс хэрэгжүүлж буй нийгмийн хөгжлийн талаарх бодлого, хувь хүний хөгжлийг дэмжсэн насан туршийн боловсрол олгоход хувь нэмэр болох давуу талтай.

Анхаарах асуудал:

- Магистрын сонгон мэргэшсэн чиглэлээр нь Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт, үнэлгээ болон Ургамал хамгааллын агрономич хөрвөх чадварыг нэмэгдүүлэх боломжтой байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх
- Төгсөгчдийн хорио цээр, хил гаалийн хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн англи хэлний төвшинг дээшлүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- “Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт, үнэлгээ” хөтөлбөрийн зорилго зорилт.
- Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны онол аргазүйн өндөр төвшиний мэдлэгтэй, ургамал хамгаалал болон бусад хавсрага шинжлэх ухааны судалгааны аргуудыг эзэмшсэн, туршилт судалгааны ажил бие даан гүйцэтгэж, үр дүн үнэлэлт дүгнэлт өгөх, газар тариалан, ургамал хамгаалал, ургамлын хорио цээрийн салбарын дотоод, гадаад хөдөлмөрийн зах зээлд хөрвөх чадвар.
- Төгсөгчдийн мэргэжлийн мэдлэг чадварын түвшин, үнэлгээ.

Онцлог зүйл/Туршлага:

- Сургуулийн удирдлага, багш нарын зүгээс төгсөгчидтэй уулзалт хийх мэргэжлийн талаар сэтгэл ханамжийн судалгааг явуулдаг.
- Төгсөгчдөөс сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сайжруулах, шинэ хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлох зорилгоор судалгаа, санал асуулга авч, дүгнэлт хийдэг.
- Сургууль, багш, төгсөгчид эргэх холбоотой байна.

Анхаарах асуудал:

- Тус хөтөлбөрөөр сургалт явуулж буй микробиологийн лаборатори, шавь тодорхойлох, англи хэл гэх мэт зарим хичээлийн агуулгад сайжруулалт хийх талаар анхаарах. Үүнд: онолын мэдлэг дутмаг, орчин үеийн багаж төхөөрөмжтэй ажиллах талаар сул гэж ажил олгогчид санал хэлж байсан.
- Сургалтын орчин, материаллаг баазыг (тоног төхөөрөмж) сайжруулах, судалгааны орчин үеийн арга зүй, сурах бичиг (мэргэжлийн) дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Зөвлөмж:

- Оюутны сургалт, судалгааны ажил дэлхийн хөгжилтэй зэрэгцэж явах ёстой.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3. Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшиний судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээл заах улирал, кредитийн задаргаа, заах багш, холбогдох хаяг, утас, ажлын өрөө, MULS хаяг, үндсэн болон нэмэлт сурах бичиг, ашиглах материал, хичээлийн өмнөх холбоо, хичээлийн тодорхойлолт, зорилго, оюутныг үнэлэх хэлбэр, хичээд суусан/оролцсон байдлыг үнэлэх арга, хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт (CLO), хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар ба хичээлийн агуулгын хамаарал, хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, боловсруулсан багш, шинэчилсэн огноо зэргийг багтаасан хичээлийн стандартын загвартай.
- Уг хөтөлбөрөөр суралцагч сургалтын төлөвлөгөөний дагуу мэргэжлийн суурь 10 багц цаг, мэргэшүүлэх 12 багц цагийн хичээлийг сонгон суралцана. Судалгааны семинар 4, магистрын ажил 7 нийт 33 багц цагийн хичээл судлан төгсөж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Тухайн хөтөлбөрөөр 2015, 2017 онд төгсөгчдөөс санал, асуумж авч судалгааны дүнг хөтөлбөрийн шинэчлэл хийхэд ашиглаж мэргэжлийн суурь заавал судлах хичээл 6 кредитээр нэмэгдүүлсэн.
- Ажил олгогч, төгсөгчдөөс нэгдсэн байдлаар судалгаа авахаар ажиллаж байна.
- Судалгааны чиглэл бүрийн дагуу олон улсын индекстэй болсноор мэргэшүүлэх чиглэл бүрээр магистрын сургалт явуулах эрхтэй.
- Тус хөтөлбөрөөр магистрант бүр ганцаарчилсан төлөвлөгөө хийж, сургалтын үйл явцаа төлөвлөх, өөрөө удирдах боломжтой.
- Онол практикийг хослуулсан хэлбэрээр нарийн мэргэжилд мэргэшин төгсдөг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдэд дүйцүүлэлт хийж байгаа нь зарим суралцагчдад нэмэлт хичээл судлах нөхцөл бүрдүүлж буйд анхаарах
- Төгсөгчдөөс тоон боловсруулалтын буюу статистик, мэргэжлийн англи хэл, ой, ойн нөхөн сэргээлтийн хичээл, хорио цээрийн болон хил гаалийн хууль эрх зүйн мэдлэг олгох чиглэлээр сэдэв оруулах хүсэлт байгааг уламжилсан.

Зөвлөмж:

- Цаашид “Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт, үнэлгээ” хөтөлбөрийн оюутнуудад зориулсан тусгайлсан чиглүүлэх сургалтыг бий болгон хэрэгжүүлж оюутнууд өөрийн мэргэжлийн онцлог давуу талыг мэдрэхэд нь түлхүү анхаарч ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.4. Хичээлийн хөтөлбөрүүд

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

Тус хөтөлбөрт мэргэжлийн суурь хичээлийн 10 багц цагт Судлаачийн ёс зүй, судалгааны ажлын төлөвлөлт, бүтээл бичих арга, Хээрийн судалгааны арга зүй, Ургамал хамгаалах цогц аргын менежмент зэрэг 4 хичээлийг судалдаг. Мэргэшлүүлэх 12 хичээлээс суралцагч нь 12 багц цагийн хичээлийг сонгон суралцахаар төлөвлөгдсөн. Суралцагч нь өөрийн судалгааны нарийн чиглэлтэй уялдуулан сонголтоо хийж, суралцах боломжтой байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилго нь хүрэх үр дүнгээр тодорхойлогдох бөгөөд хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO) болон хичээл бүрийн суралцахуйн үр дүн (CLO)-ээр матриц хийж, сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага хоорондын уялдааг тодорхойлсон.
- Мэргэжлийн ур чадвар олгох нарийн мэргэжлийн хичээлүүд нь зориулалтын орчинд, туршилт судалгаа явуулах замаар дадлагад суурилдаг бол зарим

хичээлүүд холимог хэлбэрээр сургалтын аргуудыг хослуулан хэрэглэдэг байна.

- Магистрын зэрэг олгох хөтөлбөр нь илүү хэрэглээ рүү хандсан салбар шинжлэх ухааны үндсэн зарчим, судалгааны нарийн арга техник эзэмшүүлэх, шинжлэх ухаанд хувь нэмэр оруулахуйц үр дүн гаргаж, ирээдүйд инновац болох магадлал бүхий суралцахуйн үр дүнд хүргэхэд ахисан түвшний суралцагчийг чиглүүлдэг байна.
- Хээрийн судалгааны арга зүй хичээлээр шинжлэх ухааны таамаглал дэвшүүлж сэдэв сонгох. Хээрийн туршилт, судалгааны ажлын арга зүй боловсруулах, төлөвлөх. Арга зүйн дагуу хээрийн туршилт, судалгааны ажил гүйцэтгэж, тоон материалд боловсруулалт хийж, үнэн зөв дүгнэлт гаргах.
- УХЦА-ын менежмент хичээлээр хөнөөлт организмын учруулах эрсдлийг урьдчилан таамаглах. Хөнөөлт организмоос үүсгэх эрсдлийг бууруулах хүчин зүйлийг тодорхойлох. Оновчтой тэмцэх аргын менежментийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үүссэн нөхцөл байдалд зөв дүн шинжилгээ хийх, тухайлбал ургамлын өвчний халдварын түвшин, шавжийн ургамалд учруулсан гэмтлийн зэргийг ойлгох, тэмцэх цогц аргын менежментийн шийдвэр гаргах Химийн пестицидийн хэрэглээг бууруулсан тэмцэх аргын хөтөлбөрийг төлөвлөх, хэрэглэх мэдлэг, чадвар эзэмшинэ.
- Хөрс судлал хичээлээр хөрсний гарал үүсэл, эх чулуулгийн химийн найрлагыг мэдэж сурах, хөрсний шинж чанарууд, тэдгээрийн өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлүүдийг ялгаж тодорхойлох. Хөрсний онцлогт тулгуурлан ашиглах технологи боловсруулах мэдлэг олгоно. Хөрсний шинж чанарууд тэдгээрийн онцлогт тулгуурлан ХАА-д болон бусад салбарт тохиромжтой байдлыг тогтоох, хөрсний онцлогоос хамаарсан технологи боловсруулах мэдлэг, чадвар эзэмшинэ.
- Тогтвортой газар тариалангийн систем хичээлээр газар тариалан эрхэлж буй аж ахуйнуудын үндсэн элементийн системийг удирдах, үнэлэх, тариалах талбайн орчин үеийн бүтцийг төлөвлөх, хувийн, ХАА-н таримлыг бордоход экологийн үндэслэлтэй, нөөц, энерги хэмнэсэн систем боловсруулах, хог ургамалтай тэмцэх арга хэмжээний байгаль хамгаалах системийг боловсруулах, ХАА-н таримлын усалгааг явуулах график боловсруулах, таримлын ус хэмнэсэн усалгаа, усалгаатай талбайн давсжих, намагжих, хужирсах болон усалгааны элэгдлийг арилгах, услах үед хүн амын эрүүл ахуйг хамгаалах аргыг авч үзэх, усалгааны эх булагтай харьцах дүрэм, техник аюулгүй ажиллагааг боловсруулах мэдлэг, чадвар эзэмшинэ.
- Шавжийн судалгааны аргууд хичээлээр онолын мэдлэгийг практикт хэрэглэх, гадаад дотоодын судлаачдын судалгааны үр дүнтэй харьцуулах, дүн шинжилгээ хийх, тайлбарлах. Өөрийн судалгааны ажилтай холбоотой, шаардлагатай мэдээллийг олж авах, үр дүнг нэгтгэх, боловсруулалт хийх,

баталгаажуулах зураг, тахирмаг зохиох, асуудлыг шийдвэрлэх, зохион байгуулах, төлөвлөх, тайлагнах, дүн шинжилгээ хийх. Үе хөлтөн амьтадын судалгаанд мэргэжлийн сэтгэлгээгээр хандах, байгаль юмс үзэгдлийн хоорондын хамаарлыг бүхлээр нь олж харах, харилцан хамаарлыг ойлгох, ач холбогдол ба хөнөөлөөр нь ангилан ялгах чадавхтай болно.

- Ургамлын өвчний судалгааны аргууд хичээлээр өвчин үүсгэгчийн тэдгээрийн тархах, халдварлах механизм, тархалтын цар хүрээг ойлгох. Ургамлын өвчний хөгжлийн далд үе, гадаад орчны нөлөөлөлийг холбон ойлгох, ургамалд өвчин үүсгэгч бичил биетнүүдийн патогенезийн үйл явц судлах аргуудыг мэдэх. Таримал ургамлын өвчлөлтийн тархалт, халдварлалтын цар хүрээг тогтоох, илрүүлэх, оношлоход стандарт болоод орчин үеийн арга барилыг хэрэглэх чадвард суралцана. Хээрийн нөхцөлд таримлын өвчлөлтийн тархалт, хөнөөлийг тооцох, лабораторид фитпатоген паразит болоод сапрофит бичил биетнийг өсгөвөрөөр шинжлэх, зохиомол халдварлалт хийж судлах, тестийн оношилгоог хийх дадлагыг эзэмшинэ.
- Таримал ургамлын судалгааны аргууд хичээлээр таримал ургамлын жингийн болон хэмжээсийн хэмжилт / нэгэн ялгааны зарчим / ажиглалт судалгаа хийх, туршлага судалгааны үр дүнг боловсруулах ур чадвар олгоно.
- Ургамлын физиологийн судалгааны аргууд хичээлээр Абиотек, биотек стрессийн харилцан үйлчлэлийг тодорхойлох, ургамлын өсөлт, хөгжилтийн физиологийг тайлбарлах, орчин зүйн тааламжгүй орчинд дасан зохицож ургах чадвар, стресс-ийн өөрчлөлтийг тодорхойлох. Ургамал хамгаалдаг хоёрдогч метаболизмыг ажиглах, ургацын бүтээмжийг нэмэгдүүлэхэд физиологийн үндэслэл, шийдвэрлэх арга замыг тодорхойлох. Хөнөөлт шавьж, өвчин үүсгэгчид илэрсэн үеийн ургамалд илрэх физиологийн өөрчлөлтийг үнэлэх аргазүйн мэдлэг, чадвар эзэмшинэ.
- Ургамлын өвчин, хортны прогноз хичээлээр хөнөөлт организм тус бүрээр (өвчин, хортон шавьж, мэрэгч амьтад,) прогноз боловсруулах, судалгааны ажлын үр дүнг нэгтгэн программ, мэдээллийн бааз ашиглан боловсруулалт хийх. Хөнөөлт организмын гаралт, тархалт, хөгжлийн хувь хэмжээг тухайн бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогтой холбон тархалтын урьдчилсан төлөвийг тогтоох мэдлэг, чадвар эзэмшинэ.
- Пестицидийн токсикологи, метаболизм хичээлээр пестицидийн химийн нэгдлүүдийн шинж чанар, үйлчлэх механизмийг тогтоох, тэдгээрийн хоруу чанарыг үнэлэх болон үүсэх эрсдлийг бууруулах аргачлал боловсруулах. Пестицидийг ашиглах зохистой хугацаа, тун норм, хэрэглэх технологийг тогтоох, пестицидийн хүний эрүүл мэнд, экологийн бүрдэл хэсгүүдэд үзүүлэх хоруу чанар, үйлчлэл, үлдэцийн тоон баримт цуглуулах, тэдгээрт дүн шинжилгээ хийх, боловсруулах, тайлбарлах мэдлэг, чадвар эзэмшинэ.

- Молекул биологийн судалгааны аргууд хичээлээр ургамлын өвчин үүсгэгчийг молекул оношлогооны аргыг ашиглан дархлааны оношлогооны аргууд, ДНХ-ийн оношлогоо, микроорганизмийн био-мэдрэгч, молекул маркэрүүд, молекул оношлогоонд ашиглагдах тоног төхөөрөмж болоод элаза тест, эсрэг-ген эсрэг-биеийн харилцан үйлчлэл зэрэг арга зүйг нарийвчлан тайлбарлах чадвар, мэдлэг, дадлыг эзэмшинэ.
- Хүрээлэн буй орчны эрсдлийн үнэлгээ хичээлээр хүрээлэн буй орчны эрсдлийг үнэлэх үнэлгээний үе шат тэдгээрийн төлөвлөлт, тохирох аргачлал боловсруулах, эрсдлийн үнэлгээний хүрээнд хээрийн болон лабораторийн туршилт судалгаа явуулж тоон мэдээлэл цуглуулах, боловсруулах. Хүн ба хүрээлэн буй орчинд үзүүлэх эрсдлийг үнэлэх, эрсдлийн түвшинг тогтоох, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх тохиромжтой хувилбарыг сонгох мэдлэг, чадвар эзэмшинэ.
- Мэрэгч амьтны судалгааны аргууд хичээлээр мэрэгчдийн тоо толгойг хянах арга-зүйг тайлбарлах, мэрэгчдийн харьцангуй нягтралыг тогтоох, үнэмлэхүй нягтралыг тогтоох, тархалтын коэффициентийг тодорхойлох аргуудыг эзэмших. Хөнөөлт мэрэгчидтэй тэмцэх арга- зүй, ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөг судлах зэрэг мэдлэг чадвар олгоно.
- Хүрээлэн буй орчны микробиологи хичээлээр бичил биетний янз бүрийн физиологийн бүлгийн харилцан хамаарлыг судлаж тэдгээрийн байгаль дахь идэвхтэй үйл ажиллагааг тодорхойлон экосистемд үзүүлэх нөлөөг таньж мэдэх, бичил биетний идэвхтэй үйл ажиллагааг байгалийн болон лабораторийн нөхцөлд судлана. Ургамлыг микробиологийн аргаар хамгаалах онол, арга зүй, технологи эзэмшинэ. Бичил биетний экологийн талаарх ойлголт, онол, ур чадварыг кейс, төсөлт ажлуудаар дамжуулан эзэмшиж байгаль орчны салбарт шинэ технологи, инновацыг нэвтрүүлж, хөгжүүлэх чадварыг эзэмшинэ.

Онцлог зүйл/Туршлага:

- Онолын мэдлэг, судалгааны аргазүйг бодит кейс дээр, талбайн болон хээрийн дадлага, төсөлт ажлуудаар дамжуулан чадвар, дадал болгон эзэмшүүлдэг.

Анхаарах асуудал:

- Шинжлэх ухаан хөгжих хэрээр судалгааны шинэлэг аргууд бий болж байгаа өнөө үед жил бүр хөтөлбөрөө шинэ нээлт, шинэ арга, шинэ мэдээ баримтаар баяжуулах

Зөвлөмж:

- Хөтөлбөр боловсруулахдаа оюутанд олгох мэдлэг чадвар дадлыг хичээл бүр, сэдэв бүрээр алхамчлан дэлгэрэнгүй болгон боловсруулах.
- Судалгааны арга зүйг жил бүр сүүлийн үеийн дэвшилтэт арга зүйгээр баяжуулан боловсруулдаг байх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.5. Хөтөлбөрт тавих тусгай шаардлага

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.

Илрэл нотолгоо:

- Сургалтын агуулгыг хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй уялдуулан шинэчлэх, чанарын баталгаажуулалтыг хангах ажлыг ХААИС-ийн “ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ”-ын журмын хүрээнд хэлэлцүүлж мөрддөг.
- Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт, үнэлгээ магистрын сургалтын хөтөлбөр нь 2003 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд Монгол улсын БСШУ-ны сайдын 2014 оны А/370 тоот тушаалын дагуу 08110104 индекстэй байна.
- 2003, 2009, 2011, 2015, 2017 онуудад сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулсан.
- Хөтөлбөрийн чанарын хяналт, баталгаажуулалтыг хөндлөнгийн болон дотоод хяналт хариуцсан гишүүд нь А/370-ын 2,11,1-т заасан үнэлгээний үзүүлэлтээр судалгаа хийж дүгнэн шинжлээд, хөтөлбөрийн хороонд тайлагнах зарчмаар явагдана. Эдгээр гишүүдийн тайлангаас гарсан санал шүүмжийн дагуу хөтөлбөрийн хороо нь сургалтын үйл ажиллагаа сайжруулах, хөгжүүлэх бодлогыг баримтлан ажилладаг.
- Сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтанд PDCA мөчлөгийн аргыг ашигласнаар үйл явцыг хянах, зохих удирдлагаар хангах, сайжруулах боломжтой болсон.
- Е-сургалтыг нэвтрүүлж хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд (ONEMIS), Elademy, Googleclass room зэрэг цахим программуудыг ашиглаж хичээлийг зайн хэлбэрээр судлуулж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу (PDCA)-ийн зарчмыг удирдлага болгон ажилладаг.
- Суралцагч магистрантуудын дунд сургалтын үйл ажиллагаанд хэр сэтгэл ханамжтай байгаа талаар тодруулах зорилгоор сүүлийн жилүүдэд өөрийн

сургуулийн онцлог, сургалтын хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаатай уялдуулан жиших замаар судалгааны асуултуудыг боловсруулж SMART-PLS-3.0 программаар суралцагчдад нөлөөлөх олон хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ хийдэг.

Анхаарах асуудал:

- Төгсөөд гарч байгаа мэргэжилтнүүд ажлын байранд очоод сүүлийн үеийн зарим багаж хэрэгсэлтэй ажиллах мэдлэг, чадваргүй байна гэж ажил олгогч нараас хүсэлт ирсэн.

Зөвлөмж:

- Зайн хэлбэрээр суралцах боломжийг бүрэн хангах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

2.1 Элсэлт

Элсэгчид тавих шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOEFL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

Илрэл нотолгоо:

- Магистр, докторын хөтөлбөрийн нэгдсэн удирдлагын нэгж нь “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ын 1.3-т заасны дагуу Магистр, докторын сургуультай.
- Элсэлт авах тухай зар олон нийтэд нээлттэй, хэвлэл мэдээлэл, ХААИС-ийн албан ёсны вэб сайтаар 2-3 долоо хоногийн өмнө тавигддаг бөгөөд элсэхийг хүссэн хүн бүхэнд нээлттэй.

- УХХЦҮ магистрын хөтөлбөрөөр шинжлэх ухааны магистрын хөтөлбөрт суралцахыг хүсэгчдийн шалгалтыг Магистр, докторын сургууль зохион байгуулдаг бөгөөд энэ нь шударга, ил тод байдлаар явагддаг.
- Гадаадын суралцагч монгол хэлээр сургалтад хамрагдах шаардлагыг хангасан байх бөгөөд хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр их сургуулийн гадаад хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн дагуу элсүүлнэ.

Онцлог зүйл/Туршлага:

- Бакалаврын болон түүнтэй дүйцүүлэх боловсрол эзэмшсэн байна.
- Өмнө эзэмшсэнээс өөр мэргэжлээр магистрын хөтөлбөрт хамрагдах бол сургалтын залгамж чанарыг хангахад шаардагдах хичээлийг урьдчилан судалдаг.
- Хөтөлбөрийн онцлогоос хамааран элсэгсдэд хөтөлбөрийн хороо болон сургуулийн зүгээс бусад нэмэлт шаардлага тавьж болох ба энэ нь олон улсад баримталдаг нийтлэг жишигт нийцсэн байна.
- Ургамал хамгаалал, хорио цээрийн мэргэжлийн чиглэлээр магистрт элсэгчдийн тоо нь төгсөн гарч буй оюутнуудын тоо болон оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бакалаврын төгсөлтийн ажлын чанартай шууд холбоотой байдаг.
- Бакалаврын III үйлдвэрлэлийн дадлагын 5 сарын хугацааны их дадлагын явцад ихээхэн анхаарал тавьж байнгын холбоотой ажилладаг.

Анхаарах асуудал:

- Бакалаврын оюутан магистрын сургалтад хамаарагдан судалгааны ажлаа цаашид үргэлжлүүлэн ахисан түвшинд гүйцэтгэх хүсэл эрмэлзлэлтэй болгох.
- Элсэгчид нь төгсөгчдөөсөө их байгаа нь цаашид ахисан түвшинд суралцах хүсэлтэй оюутнууд олон байдаг ч ар гэр, ажил хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн боломж, хувийн шалтгаанаас хамаарч, хойшлох, жилийн чөлөө авах тохиолдол цөөнгүй.
- Магистрын түвшний үнэлэмж болоод цалин хөлсний нэмэгдэл олгох талаар боловсон хүчний бодлого, хууль, журамд тусгах тухайн мэргэжлийн мэргэшсэн мэргэжилтний стандарттай болох нэн шаардлагатай байна.

Зөвлөмж:

- Мэргэжлийн суртачилгааг хортон шавьжгүй, өвчингүй эрүүл ургамал, эрүүл хоололт, эрүүл хүнсээр дамжуулан сурталчлах
- Хөдөө орон нутагт ажиллах ажлын байр, хангамж, нөхцөлийг сайжруулах
- Хөтөлбөрийн нэрэнд “агрономи” нэрийг нэмж оруулах дээр анхаарах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг

Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрт жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магистрын сургалтын хөтөлбөр элсэлт төгсөлт болон хичээлийн жил нь “намар”, “хавар” гэсэн хоёр улиралтай.
- Суралцах хугацаа 1.5-2 жил, хүндэтгэх шалтгаантай бол 4 жил хүртэл сунгадаг.
- Хөтөлбөрийн сургалтад онлайн нээлттэй, зайн сургалтын арга хэлбэрийг ашигладаг.
- Мэргэжлийн суурь хичээл 10 кр, мэргэшүүлэх хичээл 12 кр, судалгааны семинар 4 кр, магистрын судалгааны ажил 7 кр хийт 33 кр судалдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хороо, сургуулийн зүгээс академик эрх чөлөөгөөр хангадаг.
- Элссэн улиралдаа багтаан судалгааны ажлын сэдэв, удирдагчаа сонгон батлуулдаг.
- Сурах чиглэлээ өөрчлөх хүсэлт гаргавал тэнхим, профессорын баг, удирдагч багштай хэлэлцэн элсэх журам зөрчөөгүй бол зөвшөөрдөг.
- Магистрантын өөрийн хүсэлтээр эсвэл төгсөх хугацаа 2 жил хэтэрсэн тохиолдолд сургуулиас чөлөөлдөг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр дээрээ магистрын оюутнуудад зориулсан өрөөтэй болох (ширээ сандал, компьютер, интернет, ном сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэлийн мэдээлэлийн сан)

Зөвлөмж:

- Зайнаас суралцах боломжийг хангах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн Захирлын 2014 онд батлагдсан “ХААИС-ийн магистр, докторын сургалтын журам”-ын 2.8-д магистрын сургалтад багшлах бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг тодорхой тусгасан байна.
- Магистрын хөтөлбөрт хичээл заадаг багш нар 100% докторын (Ph.D.) зэрэгтэй, 75-аас дээш хувь нь профессор, дэд профессорын зэрэглэлтэй, олон улсын, үндэсний төсөл хөтөлбөрийн удирдагч, гүйцэтгэгчээр ажилладаг, өндөр хөгжилтэй дэлхийн улс орнуудад суралцаж төгссөн, мөн мэргэжил дээшлүүлсэн, сургалтад хамрагдсан.
- Магистрын хөтөлбөрт оролцдог багш нар нь суралцагч оюутнуудад ургамал газар тариалан, ургамал хамгаалал, хорио цээрийн салбарын бодлого, хөгжилд хувь нэмэр оруулах магистрын зэрэгтэй, судалгааны арга зүйд бүрэн суралцсан, нийгмийн хөгжлийг үлгэрлэн манлайлах, ёс зүй, харилцаа, хандлагыг эрхэмлэн дээдлэгч мэргэжилтэн бэлтгэдэг.

Онцлог зүйл/Туршлага:

- Хөнөөлт организмын хөнөөлийг ургамлын төрөл, зүйл, биологи, физиологи, эсийн ба, молекулын түвшинд тулгуурлан судлах, практик мэдлэг олгодог.
- Хөнөөлт организм/ ургамалд өвчин үүсгэгч бичил биетэн, гэмтэл учруулагч хачиг, шавж, хог ургамал ба бусад/ болон ашигтай макро, микроорганизм/ ангуучин, шимэгч хачиг, шавж болон бусад бичил биетэн/-ыг таних, тодорхойлох
- Хөнөөлт организмтай тэмцэх химийн болон синтетик нэгдлийн пестицид, биологи, микробиологийн гаралтай биопестицид, эм бэлдмэлүүдийг туршдаг.
- Монгол Улсад хорио цээртэй хөнөөлт организм илэрсэн болон илэрч болох түүхэн эх сурвалжуудыг судалсан байх, илэрсэн, тархсан тохиолдолд авч хэрэгжүүлэх оновчтой арга замыг авч хэрэгжүүлэх, учир шалтгааныг судалдаг.

Анхаарах асуудал:

- Сүүлийн үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, багаж, эм урвалж, сурах бичгээр хангах

Зөвлөмж:

- Мэргэжлийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.4 Судалгааны ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Удирдагч багшийг сонгох, томилох нь тухайн суралцагчийн өөрийн сонголтын үндсэн дээр явагддаг.
- Удирдагч багш, оюутан харилцан зөвшилцөж судалгааны чиглэл, үр дүнгийн таамаглалыг дэвшүүлж ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулан Магистр, докторын сургуулийн захирал баталгаажуулдаг.
- Суралцагчид мэргэжлийн суурь хичээлээ үзэж дууссаны дараа судалгааны ажлын арга зүйг удирдагч багшийн хяналт, заавар зөвлөгөөний дагуу боловсруулж харьяа мэргэжлийн профессорын баг, тэнхимийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Удирдагч нь судалгааны ажлын сэдэв, арга зүй, судалгааны семинар зохион байгуулах, хэлэлцүүлэг, хамгаалтад зөвшөөрөл олгодог.
- Судлаач нь эрдэм шинжилгээний хуралд нэгээс доошгүй илтгэл хэлэлцүүлж, зөвшөөрөгдсөн сэтгүүлд нэг өгүүлэл хэвлүүлдэг.
- Судалгааны ажил нь тухайн сэдвээр онол, арга зүй, үр дүн, дүгнэлт, зөвлөмж бүхий нэг сэдэвт бүтээл байна.
- Судалгааны ажлын бичвэр нь 40-өөс доошгүй хуудаст багтаан монгол хэлээр бичдэг.
- Профессорын баг нь хамгаалалтанд орох зөвшөөрлийг өгдөг.

Анхаарах асуудал:

- Магистрантын судалгааны ихэнх зардалыг удирдагч багш өөрсдийн судалгааны төслөөс гаргадаг.
- Зарим тохиолдолд судалгааны зардлаа оюутан өөрсдөө гаргадаг.

Зөвлөмж:

- Судалгааны ажлын үр дүнг олон улсын сэтгүүлд хэвлүүлэх боломжоор хангах
- Удирдагч багш нарын ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2.5 Бүтээлч ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн хэмжээнд зохиогддог “Магистр, докторантын эрдэм шинжилгээний бага хурал.
- “Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд тэтгэлэг олгох журам”-тай.
- Олон улсын болон улсын хэмжээний төсөл хөтөлбөрүүдэд магистрант оюутнууд хамрагддаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Доктор, дэд проф. Д.Ундармаагийн удирдаж хамгаалуулсан 3 магистр оюутан 2016, 2018, 2019 онуудад их сургуулийн хэмжээнд зохион байгуулагдсан “Магистрант оюутнуудын эрдэм шинжилгээний бага хурал”-д амжилттай оролцон тэргүүн байр эзэлж тус бүр 1 сая төгрөгийн тэтгэлэгт хамрагджээ.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд багш нарын удирдсан төсөл хөтөлбөрүүдэд нийтдээ 23 магистрант оюутан оролцсон байна.

Анхаарах асуудал:

- Энэ хөтөлбөрөөр эзэмшиж байгаа мэргэжлийн ач холбогдол, давуу талыг олон нийтэд суртачилан таниулах
- Судалгаа шинжилгээний ажилд орчин үеийн судалгааны арга, тоног төхөөрөмж, урвалж бодис хэрэглэх
- Туршилтын талбай, хүлэмжийн тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Энэ мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг цорын ганц хөтөлбөр тул гадаад, дотоодын бусад их дээд сургуультай хамтран ажиллах, хамтарсан бүтээл гаргах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байна.

3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулахад чиглэсэн байна.

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУ-ы сайдын 2003 оны 158 тоот тушаалаар Дээд боловсролын зэрэг олгох сургалтад кредит цагийг хэрэгжүүлсэн. Кредит системийн дагуу оюутны мэдлэгийг 2 үе шаттай, нийт 100 оноогоор үнэлэх журмыг мөрдөж ажилладаг.
- БСШУ-ны сайдын 2014 оны А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”, мөн сайдын 2007 оны 187 тоот тушаалаар батлагдсан “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”- ийг тус тус баримтлан ажилладаг.
- Магистрантудын мэдлэг, чадварын үнэлгээ нь ХААИС-ийн Захирлын 2017 оны А/187 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “ХААИС-ийн ахисан түвшинд суралцагчдыг үнэлэх үнэлгээний журам”-ыг баримталдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцаж буй оюутны бүртгэл, хичээлийн үнэлгээ зэрэг мэдээлэл тэнхимд хэвлэмэл байдлаар болон сургалтын албанд бүртгэлийн програмд оруулж цахим хэлбэрээр гаргадаг.
- Шинэ журмаар 2015-2016 оны хичээлийн жилээс богино улирлын системд буюу 4 үндсэн, 2 нэмэлт улирлаар хичээллэх, оюутны мэдлэг, чадварыг дүгнэхдээ багш зуун хувь үнэлдэг. Оюутны мэдлэг, чадварыг үнэлж дүгнэхдээ тэдний бие даан суралцах үйл ажиллагааг хөхүүлэн дэмжиж хөгжүүлэх, оюутны сурах, багшийн сургах үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх зарчмыг удирдлага болгодог байна.
- 2018-2019 оны хичээлийн жилд багш нарын заах арга, барилын талаар суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авсан байна. Судалгаанд 60 оюутан хамрагдсанаас багшийн ур чадварыг 56-83 хувь, багшийн заах арга

зүй, хандлага 56-85 хувь, сургалтын орчин 60-85 хувь, оюутны сэтгэл ханамж 66-89 хувь буюу сайн, маш сайн үнэлгээ өгсөн байна.

- Багш хичээлийн улирлын дүнг мэдээллийн системд заасан хугацаанд оруулах үүрэгтэй. МДС-ийн мэргэжилтэн хяналт тавьж ажиллана. Суралцагч явцын, улирлын дүнтэй цаг тухайд нь танилцаж үнэлэлт дүгнэлт хийх бөгөөд гомдол маргаан гарсан тохиолдолд багшид мэдэгдэх, шаардлагатай тохиолдолд сургалтын албанд өргөдөл гаргаж шийдвэрлүүлнэ.

Анхаарах асуудал:

- Мэргэшүүлэх хичээлийн үнэлгээ 8 хичээлийн 4 жилийн дүнгээр авч үзэхэд В 26.6 хамгийн хувийг эзэлж байна. Мэргэшүүлэх хичээлийн үнэлгээ хангалтгүй байгааг анхаарах

Зөвлөмж:

- Тестийн санд буй хичээлийн агуулгад оюутнуудын авсан үнэлгээнд суурилсан харьцуулсан анализ, сайжруулалт хийх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.2. Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх
Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна.

Хөтөлбөрөөс гадуур магистрантын бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Монгол Улсын Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 тушаал (Хавсралт 5.3) Магистр, докторын мэргэжлийн чиглэл, индекс, журам батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай.
- Монгол Улсын БСШУ-ны сайдын 2014 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/370 дугаар тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ыг үндэслэн боловсруулагдсан ХААИС-ийн 2014 онд батлагдсан “Магистрант, докторантын сургалтын журам”.
- ХААИС-ийн Захирлын 2014 оны 2.7.2-д заасны дагуу бакалаврын сургалтын 15-30 кредитийг үзсэн байхаар дүйцүүлэлтийг хийж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Энэхүү мэргэжил нь ирээдүйд эрэлттэй, бие даан бизнес эрхлэх, ажлын байр бий болгох, хамгийн гол нь төрийн бодлого, хууль эрх зүйн түвшинд дэмжигдэж баталгаажсан.

Анхаарах асуудал:

- Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хүнс, хөдөө аж ахуй, газар тариаланг түлхүү хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг дэмжих мэдлэг чадвартай боловсон хүчин бэлтгэх.
- Ажил олгогч нараас УХХЦХҮ-ний мэргэжилд шаардагдах хууль эрх зүй, гадаад хэлний мэдлэг ажлын байранд тавигдах шаардлага хангахгүй байгааг уламжилсан.

Зөвлөмж:

- Хүнс, хөдөө аж ахуй, газар тариаланг түлхүү хөгжүүлэхэд нэн хэрэгтэй мэдлэг ур чадварыг эзэмшүүлж чадаж байна уу гэдэгт анализ хийж магистрын хөтөлбөртөө сайжруулалт хийх
- Хөтөлбөрөөр эзэмшсэн суралцахуйн үр дүнг хөдөлмөрийн зах зээл дээр хүлээн зөвшөөрөгдсөн байх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.3. Суралцагчийг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна.

Магистрантыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг системтэйгээр үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль
- ХААИС-ийн магистр докторын сургалтын журам

- Гадаад дотоодын их дээд сургуулиас шилжин суралцах, багц цагийн дүйцүүлэлтийг “ХААИС-д магистрант суралцагчаар шилжин суралцуулахад “Магистрант, докторантын сургалтын журам”-аар зохицуулдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийг 3,2-оос дээш голчтой төгссөн иргэн өөрөө хүсэлт гаргавал магистрантурт шалгалтгүй элсүүлж, сургалтын төлбөрийг 15 хувь хөнгөлнө.
- Магистрантуудын хамрагддаг клубын үйл ажиллагаанд зардал төсөвлөдөггүй.
- “Эерэг өнцөг” клуб, « Ландшафт дизайн” клуб, “Ургамлын өвчин судлал-В8”, “Ургамлын эмнэлэг” гэсэн 2 дугуйлан тогтмол явуулдаг.
- “Судалгааны аргазүйн семинар”-ыг жил болгон тогтмол зохион байгуулдаг.
- ХААИС-ийн профессор багш, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлийн мэдээллийн санг үүсгэх, магистрантын төгсөлтийн ажил, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны төсөл болон бусад бүтээлүүдээ байршуулдаг онлайн санг бүрдүүлэх, судлаачдын судалгааны ажлын үр дүнгээр инновацын бүтээгдэхүүний сурталчлах каталогиор олон нийтэд сурталчлах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Суралцахуйн үйлийг дэмжих, зөвлөхдөө хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, тухайн оюутны нөхцөл байдалд үнэлгээ хийх.

Зөвлөмж:

- Магистрантыг амжилттай суралцахад дэмжих, зөвлөх үйлчилгээг өгөхдөө орчин үеийг судалгааны лабораторийн орчин нөхцөлийг бүрдүүлэх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.4. Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журамтай байна.

Илрэл нотолгоо:

- Шинжлэх ухаан, технологийн төсөл хөгжүүлэх журам
- Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах журам
- Оны шилдэг технологи шалгаруулах журам

- ХАА-н салбарын залуу судлаачдад инновацын грант олгох журам
- Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд тэтгэлэг олгох журам
- "ХААИС-ийн судалгааны төсөл сонгон шалгаруулах. санхүүжилтын журам"
- "Судлаач оюутан" хөтөлбөр

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрант, докторант оюутны 75-80 орчим хувь нь төсөл хөтөлбөрт хамрагддаг.
ХААИС-ийн ахисан түвшний суралцагчдад зориулан судалгааны грант бий болгон өрсөлдөөний журмаар санхүүжүүлж байна.

Анхаарах асуудал:

- Магистр, докторын сургууль магистрантын судалгааны ажлын үйл ажиллагаанд сургалтын төлбөрийн 5 хувийг зарцуулна гэж журамд тусгасан байдаг ч зарцуулдаггүй байна. Үүнийг цаашид анхаарч журмыг баримтлан ажиллах.
- Төсөлд хамрагдаагүй магистрантуудын судалгааны санхүүжилтийг шийдвэрлэх

Зөвлөмж:

- Судлаач оюутны судалгааг дэмжихийн тулд мэргэжлийн профессор багш нарыг гадаад, дотоодын санхүүжилттэй төсөлд хамруулах нөхцөлийг бүрдүүлэх, ижил төстэй мэргэжлийн болон ажил олгогч байгууллагуудтай хамтран ажиллах санамж бичиг, гэрээ хийх гэх мэт санхүүжүүлэх олон талт эх сурвалжийг бий болгох
- УХХЦХҮ-ний ахисан түвшний суралцагчдад мэргэжлийн онцлогоос хамаарч бодит орчин нөхцөлд дадлага, судалгааны ажлыг хийсэн байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.5. Тэтгэлэг, тэтгэмж

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзолыг тодорхой заасан дүрэм журамтай байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай Монгол Улсын хууль (сурлагын амжилтыг харгалзан үндэсний тэтгэлэгт хамруулах);

- Монгол улсын хөдөө аж ахуйн их сургуулийн дүрэм
- ХААИС-ийн хөтөлбөрийн хорооны журам
- Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам
- Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам
- Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацын тэтгэлэг олгох журам
- Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах журам У ХАА-н салбарын залуу судлаачдад инновацын грант олгох журам
- Магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг бүтээлд тэтгэлэг олгох журам
- ХААИС-ийн АЭС, МДС-ийн эрдэм шинжилгээний хурлын шилдэг ИЛТГЭЛ шалгаруулах тушаал (2016-2020 он).

Онцлог зүйл/Туршлага:

- Агроэкологийн сургууль магистрант, докторант оюутнуудын дунд ЭШБХ зохион байгуулж, 1-3 байр эзлэхэд мөнгөн урамшуулал (100 000-500 000 төгрөг), өргөмжлөл хадгалуулдаг.
- ХААИС-ийн захирлын 2016 оны А/45 тоот тушаал"-ын 3.5-д зааснаар шалгарсан магистрант, докторантыг ХААИС-ийн гадаад оюутан солилцооны хөтөлбөр, төсөл, судалгаа, экспедицийн ажилд нэн тэргүүнд оролцуулах бодлого баримталдаг.
- Тус журмын 4.1-д салбар бүрээс 2 илтгэлийг шалгаруулж судалгааны тэтгэлэг урамшуулна. ХААИС нь магистрантын шилдэг илтгэлд 1 000 000 төгрөгийн судалгааны тэтгэлэг олгож урамшуулдаг.
- Харин гадаад, дотоодын төсөл, гэрээт ажлуудад магистрантууд туслах судлаачаар оролцож цалинжихаас гадна судалгааны ажлын шаардлагатай эм урвалж, үр бордоо, лабораторийн техник хэрэгслийн зардлыг даалгадаг давуу талтай.
- Хөдөө аж ахуйн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, инновацын үйл ажиллагааг дэмжих, инновацд чиглэсэн судалгааны ажлыг нэмэгдүүлэх зорилгоор залуу судлаачдад 5 сая төгрөгийн грант олгодог.

Анхаарах асуудал:

- Дээрх журмын 4.2-д хэрэгжүүлэх. Магистрант, докторантыг нийт төлбөрийн 0.05 хүртэл хувийг ХААИС санхүүгийн жилийн төсөвт тусгаж судалгааны ажилд зориулан зарцуулна гэж тусгасан.

Зөвлөмж:

- Хөдөө аж ахуйн салбарын эрдэм шинжилгээ, судалгаа, туршилт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, инновацын үйл ажиллагааг дэмжих

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.6. Судалгааны баг, хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гадны судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншлэх, багш, магистрантууд судалгааны багт оролцох боломж нөхцөлийг тандан судалж, зарим ажлыг эхлүүлсэн байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн захирлын 2016 оны А/140 тушаал
- ХААИС-ийн Захирлын 2016 оны А/87 тоот тушаал, профессорын багийн ажиллах журам”

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС нь 2014 оноос судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд ХАА-н мэргэжлийн профессорын багуудыг байгуулж ажилласнаар гадаад, дотоодын урт, богино хугацааны 250 гаруй төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Сүүлийн 5 жилд ХААИС-ийн стратеги төлөвлөлтийн дагуу оюутан төвтэй судалгааны их сургууль болох зорилтын хүрээнд гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.
- Судалгааны орчин сайжруулах, ижил мэргэжлийн хөтөлбөртэй жиших, ахисан түвшиний сурагчдын солилцоо хийх замаар оюутны хөгжлийг дэмжих сайжруулах ажлууд хийгдэж байна.

Анхаарах асуудал:

- Судалгааны орчинг сайжруулах

Зөвлөмж:

- Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.7. Магистрын ажил хамгаалалт

Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлсны дагуу магистрын ажлыг тодорхой журам, удирдамжийн дагуу гүйцэтгэх орчин нөхцөл, нөөц, боломжийг бүрдүүлсэн байна.

Илрэл нотолгоо:

- БШУ-ны сайдын 2014 оны 9 дүгээр сарын 12 -ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”.
- БСШУ-ны сайдын 2010 оны 492 тоот тушаалаар батлагдсан “Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”.
- Мөн сайдын 2007 оны 187 тоот тушаалаар батлагдсан "Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”.
- ХААИС-ийн Захирлын 2014 онд “Магистр, докторын сургалт журам”.

Онцлог зүйл/Туршлага:

- МДС нь тус хөтөлбөрөөр элсэх өргөдөл гаргаснаас төгсөлтийн баримт бичгийг гардан авах үйл ажиллагаа хүртэлх сургалтын бүхий л үйл явцыг хариуцдаг.
- Магистрын судалгааны ажил удирдагч нь докторын зэрэгтэй, их, дээд сургууль эсхүл эрдэм шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, энэхүү журмын 3.1.5-д заасан эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлтэй, идэвхтэй судлаачид байна.
- Магистр, докторын судалгааны ажлын удирдагч нь өөрийн тэнхим, профессорын баг, лабораторийн түвшинд болон бусад нэгжтэй хамтарсан байдлаар магистрант, докторантын туршилт, судалгааны ажлын арга зүй, үр дүн бие даалтын ажлын явц зэргийг хуваарийн дагуу тогтмол хэлэлцүүлж, судалгааны семинар зохион байгуулдаг байна.
- Тус хөтөлбөрөөр элссэн оюутны тоо харьцангуй их боловч төгсөж чадахгүй шантрах, орхигдуулах, завсардах, ямар ч шалтгаангүйгээр холбоо тасрах хандлага цөөнгүй тохиолдоно.
- Цаашилбал, суралцагчид олон жилийн дараа дахин ирж үргэлжлүүлэн суралцаж төгсөх хүсэлтээ байгаагаа илэрхийлдэг. Иймд дахин суралцагчийн өргөдлийг МДС-ийн мэргэжилтэнгүүд хүлээн авч уян хатан нөхцөлтэйгээр үргэлжлүүлэн суралцуулахаар шийдвэрлэдэг.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлбөрийн асуудлаас шалтгаалан суралцах хугацаа хэтрэх, эрдэм шинжилгээний тоон мэдээллийг дахин цуглуулах шаардлага гарах, ар гэрийн гачигдал зэргээс шалтгаалан судалгааны ажлаа гүйцэтгэх боломжгүй болдог.

Зөвлөмж:

- Тус хөтөлбөрөөр элсэн суралцаж байгаа оюутнаас явцын дунд төгсөж чадахгүй шантрах, орхигдуулах, завсардах магадлалын шалтгааныг тогтоох судалгаа авдаг байх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.8. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлсны дагуу - магистрын ажлыг тодорхой журам, удирдамжийн дагуу гүйцэтгэх орчин нөхцөл, нөөц, боломжийг бүрдүүлсэн байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 1997 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 59 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын төгсөлтийн шалгалтын үлгэрчилсэн журам”.
- 2006 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 480 тоот тушаалаар батлагдсан “Дээд боловсролын диплом олгох журам”.

Онцлог зүйл/Туршлага:

- Тус хөтөлбөрөөр суралцагч нь нэгдсэн шалгалтанд 75 хувиас доош үнэлгээ авсан тохиолдолд дараагийн улирлын шалгалтын хугацаанд дахин шалгалт өгөх эрхтэй бөгөөд 2 удаа амжилтгүй дүн үзүүлбэл магистрын зэргийг олгохгүй ба цаашид мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн хөтөлбөрийн сургалтад төлбөртэй хамрагдана.

Анхаарах асуудал:

- Олон улсад суралцахад шаардлагатай төгсөлтийн баримт бичиг

Зөвлөмж:

- Тус хөтөлбөрөөр суралцагч нарын үнэлгээнд мониторинг судалгаа явуулж нэгдсэн шалгалтанд орохоос өмнө 75 хувиас доош үнэлгээ авах магадлалтай оюутанд зөвлөмж өгөх.
- Олон улсад суралцахад шаардлагатай төгсөлтийн баримт бичгийн нэмэлт хавсралт (*Diplom supplement*) үйлдэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн

Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

4.1. Багшийн нөөц

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой тогтоож, мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрт хичээл заах багшийн шалгаруулалт, шаардлага нь ХААИС-ийн захирлын 2017 оны 04 сарын 20-ны өдрийн А/86 тоот тушаалын дагуу гарсан ХААИС-ийн профессор багш ажиллуулах журмаар зохицуулагддаг.
- “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-д нийцүүлэн багшийг сонгож, хүний нөөцөө бүрдүүлэн ажилладаг.
- Хөтөлбөрт орох хичээлүүд болон багшлах бүрэлдэхүүнийг сонгохдоо хөтөлбөрийн хороогоор хэлэлцэх ба хөтөлбөрийн хорооны бүрэлдэхүүнийг Эрдмийн зөвлөлийн санал, дүгнэлтэд үндэслэн сургуулийн захирал
- Магистр, докторын судалгааны ажлын удирдагч нь өөрийн тэнхим, профессорын баг, лабораторийн төвшинд болон бусад нэгжтэй хамтарсан байдлаар магистрант, докторантын туршилт, судалгааны ажлын арга зүй, үр дүн бие даалтын ажлын явц зэргийг хуваарийн дагуу тогтмол хэлэлцүүлж, судалгааны семинар зохион байгуулдаг байна гэсний дагуу дараах байдлаар багшийн сонголтыг хийж УХХЦХҮ-ний магистрын хөтөлбөрт хичээл заах багш нарын бүртгэлд 13-15 багш бүртгэлтэй байна
- Магистрын хөтөлбөрт хичээл заах багшийн тушаалыг жил бүрийн хичээл сонголтын хуваарийн дагуу МДС-ийн захиралын тушаал гарч баталгааждаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Шинжлэх ухаан, үйлдвэрлэл практикийн болон ахисан түвшний сургалт, судалгааны ажлын туршлагатай, мэргэшсэн багшийг холбогдох чиглэлээр зочин багшаар урьж ажиллуулдаг.
- Судалгааны ажлын удирдагч нь докторын зэрэгтэй, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай, эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн байна.
- Магистрын хөтөлбөрт тус сургуулийн болон эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн багш, судлаач нар 10-12 мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлүүдийг тэнхимийн болон хээрийн сургалт судалгааны төвүүдэд ордог байна.
- Нийт хичээл ордог багш нар 100% доктор зэрэгтэй, 90% нь профессор, дэд профессор зэрэгтэй, ургамал хамгааллын агрономч, ургамал хамгаалал хорио цээрийн хяналт үнэлгээ, агрономч, хөрс судлаач, молекул биологи, микробиологийн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн багш нар хичээл зааж байна.
- Тухайн хөтөлбөрийн магистрын хөтөлбөрт хичээл заадаг багш нар нь 8-33 жилийн хугацаанд тухайн салбартаа ажилласан, гадаад, дотоодын төслүүдийг удирдахын зэрэгцээ, төсөлд оролцдог, судалгаа шинжилгээний ажил хийж, зөвлөгөө өгдөг байна.

Анхаарах асуудал:

- Багшлах боловсон хүчний ажиллах нөхцөлийг сайжруулах
- Багш нарыг тодорхой хугацаанд сургалтанд хамруулах, гадаад хэлний мэдлэгийг сайжруулах

Зөвлөмж:

- Багш, төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.2. Багшлахуйн үнэлгээ

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийдэг. ХААИС-ийн багш

нарын сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн, үйлчилгээний (зөвлөх үйлчилгээ) чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог. Жил бүр их сургууль, бүрэлдэхүүний сургууль, тэнхимийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын биелэлтийг тэнхимийн хамт олондоо өөрийн үнэлгээний тайлангаа илтгэж, баримт материалаа баталгаажуулан тооцдог.

- Аттестатчлалын үр дүнгээр тухайн хөтөлбөрт хичээл заадаг 4 багш дэд профессорын албан тушаалд ахиж (Д.Ундармаа, Д.Хандсүрэн, Б.Амарсанаа, Л.Даваа), 2 багш ахлах зэрэглэлд(Д.Банзрагч, Д.Энхжаргал) нар дэвшин ажилласан бөгөөд зэрэглэл буурсан багш байхгүй болно.
- Хичээл зааж буй багш нар нь сургалтын идэвхтэй, бүтээлч арга ашигладаг эсэхэд оюутны сэтгэл ханамжийн түвшинг үнэлж үзэхэд 3.70 оноо буюу сэтгэл ханамж өндөр гэсэн үнэлгээ өгчээ. Харин сэтгэл ханамжийн түвшин тус бүрийн эзлэх хувийн жинг авч үзвэл судалгаанд хамрагдсан нийт оюутны хувьд: сэтгэл ханамжтай оюутан 541 буюу 59.3 хувь, сэтгэл ханамж дунд зэрэг оюутан 226 буюу 24.8 хувь, сэтгэл ханамжгүй оюутан 145 буюу 15.9 хувь байна. Судалгааны үр дүнгээс харахад багш нарын 71.9 хувь нь бие даалтыг тогтмол шалгаж хэлэлцүүлдэг, 47.6 хувь нь оюутны санал бодлыг сонсон чөлөөт хэлэлцүүлэг явуулдаг гэж дүгнэсэн байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Ургамал хамгаалалын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтдээс багшийн нөөцийг бүрдүүлдэг.
- Ажлын байрны тогтвортой байдал, нийгмийн зарим хангамж, судалгааны ажилд боломж олгодог.
- Ургамал хамгаалал, хорио цээр, хяналт үнэлгээний мэргэжилтэн бэлтгэдэг багш нарын ажлын үзүүлэлтүүдийн дундаж үнэлгээг авч үзвэл сургалт заах аргаар 88.52%, эрдэм шинжилгээгээр 60.77%, мэргэжлийн үйл ажиллагаагаар 68.88%-ийн үнэлгээг сургуулийн болон комиссын дундаж үнэлгээгээр үнэлэгдсэн байна. Эндээс харахад багш нарын ажлыг жил бүр үнэлж ажлын үзүүлэлтийг дээшлүүлэх багш бүрийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд ахиц дэвшил гаргахын зэрэгцээ цаашид анхаарах зүйлд зөвлөгөө өгч буйн жишээ юм.

Анхаарах асуудал:

- Багш нар мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд өөрсдийн болон сургуулийн зүгээс үе шатлалтай арга хэмжээ авах, багш нарыг албан тушаалын зэрэглэлээ ахиулахад анхаарах хэрэгтэй.
- Урамшуулалын зарим системийг сайжруулах
- Багшийн цагийн ачаалал их учраас судалгаанд бага цаг зарцуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.3. Багшийн хөгжил

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инновац нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын хэмжээнд 2019 оны 1-р сарын 01-нээс мөрдсөн “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хууль, 2016 оны 6-р сарын 27-ний өдрийн хууль, ХААИС-ийн ректорын 2002 оны 11-р сарын 20-ны өдрийн 156 тоот тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөрийн бодлогын баримт бичгийг ХААИС-ийн тэнхимийн эрхлэгчдийн 2017 оны 02-р сарын 23-ний өдрийн тушаалаар сайшааж, захиргааны зөвлөлийн 2017 оны 03-р сарын 23-ний өдрийн хурлаар батлагдсан баримт бичгийг ХААИС-ийн багшийн хөгжилд мөрддөг болсон.
- ХААИС нь 2017-2018 оны хичээлийн жилд шинээр багшийн хөгжил хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийн дагуу LCE программ хангамжийг шинээр нэвтрүүлсэн байна

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар өөрсдийгөө хөгжүүлэхэд анхаарч докторын зэрэг хамгаалах, цол зэргээ ахиулах зэргээр хөгжсөөр бөгөөд сүүлийн 3 жилд доктор 1 (Н.Дамбадаржаа-2019), дэд профессор багш 2-оор (Н.Цэрэнтогтох-2017, Б.Амарсанаа-2018) нэмэгдсэн.
- Сургалтын үйл ажиллагааг сайжруулах үүднээс магистрын сургалтын хөтөлбөрт сайжруулалт хийсээр ирсэн бөгөөд 2017 онд хамгийн сүүлд шинэ загвараар өөрчилсөн байна

Анхаарах асуудал:

- Сургуулийн төсвөөс хэдэн хувийг сүүлийн жилүүдэд багшийн хөгжилд төсөвлөн, зарцуулсан талаар анализ хийхэд санхүүгийн жилийн тайлан жилээр гарах учраас онцлон төсвийн хэдэн хувь нь эрдэм шинжилгээнд зарцуулсынг харуулсан тодорхой мэдээлэл байхгүй байна.
- МДС нь магистрантын судалгааны ажлын үйл ажиллагаанд сургалтын төлбөрийн 5 хувийг зарцуулна гэж журманд тусгасан байдаг хэдий ч санхүүжилтийг шийдвэрлэдэггүй, зарцуулдаггүй дутагдалтай тал байдаг юм байна.

Зөвлөмж:

- Багш нарын судалгааны ажлын үр дүнг инновац, гарааны компани байгуулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4. Судалгаа ба хөгжил

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Дэд профессор Д.Ундармаа ахлагчтай “Биологийн нөөц, таримлын технологийн хөгжил”, доктор, дэд профессор Д.Насандулам ахлагчтай “Ургамал хамгаалал” профессорын багууд ажиллаж байна. Профессорын багууд болон багш нар өөрсдийн судалгааны ажлыг идэвхтэй хийх, олон улсын болон үндэсний хэмжээний төсөл хэмжээний төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ магистрант оюутнуудыг татан оролцуулдаг.
- Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн дээр судалгааны ажил хийж магистрын зэрэг хамгаалсан нийт 17 оюутан нь 5 удирдагч багшийн хэрэгжүүлж буй ШУТсан болон олон улсын хэмжээний 10 гаруй төсөлд оролцон нийт 17 сэдэвт ажлыг гүйцэтгэсэн байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар бүтээлээ хэвлүүлсэн байдлыг үндэслэн багшийг оны шилдэг багшийн урамшуулалаар шагнах, ХААИС-ийн болон АЭС-ийн шилдэг багшийн шалгаруулах журмын дагуу шалгаруулах, ХАА сэтгүүл, Агроэкологи сэтгүүл болон бусад үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн ISBN дугаартай сэтгүүлд англи ба монголоор өгүүлэл хэвлүүлэх эрхийг үнэгүй олгох, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн ба ишлэл татагдсан байдлыг харгалзан урамшуулал олгох зэргээр дэмждэг.
- Багш нараас сүүлийн 5 жилд олон улсын IF-тэй сэтгүүлд (0.33-5 IF) 5 өгүүлэл, мэргэжлийн гадаад хэлээр хэвлэгддэг ба гадаадад хянагддаг сэтгүүлд 37, улсын хэмжээнд 68, бүрэлдэхүүний 85 сургуулийн хэмжээнд 24, сурталчилгааны өгүүлэл 5- ийг хэвлүүлсэн байна.
- Сүүлийн жилүүдэд экологид ээлтэй газар тариаланг хөгжүүлэх, органик тариаланг хөгжүүлэх, ургамал хамгаалалын чиглэлээр Өмнөд Солонгос улсын КОЙКА, КОПИА-МОНГОЛ төв, Япон улсын ЖАЙКА ОУБ, Францын Жээрис ОУБ, АНУ-ын Глобал трайнинг центр, дотоодын БСШУЯамны ШУТсан, ХХААЯам болон бусад олон байгууллагуудтай хамтран олон улсын болон дотоодын захиалгат болон гэрээт төслийг хэрэгжүүлж байна.

Анхаарах асуудал:

- ХААИС-ийн магистрын судалгааг лаборатори, хээрийн нөхцөлд хийхэд санхүүгийн хүндрэл тулгардаг. Сургуулиас төсөв тусгадаггүй.
- Багш нар судалгааны шинэ арга зүй боловсруулж ажиллахад сургалтын бааз, лабораторийн хангамж муу байна.

- УХХЦХҮ-ний магистрын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд оруулахад сургалтын менежмент, багш ур чадвартай холбоотой бэлтгэл хангалтгүй байна.
- Профессорын багийн үйл ажиллагааг кредитийн хөнгөлөлтөөс өөр дэмжлэг үзүүлэхгүй байгаа тул хөгжих боломж муу байна.
- Багш бүр төсөл хөтөлбөрт хамрагдаж судалгааны ажлаа хийх боломжгүйгээс судалгааны ажилд санхүүгийн бэрхшээл ихээхэн дутагддаг
- Багшийн цагийн ачаалал их байдгаас хамаарч багш нар судалгааны ажилд цаг бага зарцуулдаг.
- Багш нарын ном, гарын авлагыг хэвлүүлэхэд сургуулийн зүгээс дэмжлэг муу үзүүлдэгээс хамаарч сурах бичгийн шинэчлэл муу хийгдэж байна.

Зөвлөмж:

- Судалгааны үр дүнгээр хянан магадалгаа хийгддэг гадаадын нэр хүндтэй сэтгүүлд ЭШ-ний өгүүлэл ажлыг идэвхжүүлэх
- Олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүлэл хангалтгүй (5 жилд 5 өгүүлэл) байна. Судалгааны ажлын үр дүнг заавал олон улсын “Web of science”, “Scopus”-тай сэтгүүлд хэвлүүлэх талаар багш нарыг дэмжих хэрэгтэй.
- Байгалийн ухааны шинжлэх ухаан нь (ерөнхий биологи, молекул биологи, микробиологи гэх мэт) цаг хугацаатай уралдаж хөгжиж байдаг. Иймээс англи хэл дээр хэвлэгдсэн, хамгийн сүүлийн үеийн сурах бичигтэй болох

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт

5.1. Сургалт судалгааны орчин.

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр магистрант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж, багш, суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Тус хөтөлбөрөөр сургалт явуулж буй анги, танхимын хүрэлцээ эрүүл, аюулгүй байдлыг хангасан орчин бүрдүүлсэн байдал
- Туршилт судалгааны лабораторийн тоног төхөөрөмжийн хангамж, зөвлөмж гарын авлагаар хангасан байдал
- Сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн төвүүд. Сургалт, судалгааны төвүүдэд магистрантууд арга зүйн дагуу туршилт судалгааг хийж гүйцэтгэдэг бөгөөд

үйлдвэрлэлийн талбай дахь судалгааны ажлын арга зүйн анхны хэлэлцүүлгийг профессорын багийн хүрээнд хийж, түүний дараа тэнхимээр хэлэлцэн баталж заавар, удирдамж, зөвлөмжийг оюутан тус бүрд нэг бүрчлэн тайлбарлан таниулж удирдлагаар 100% хангаж судалгааг явуулдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- 2020 оны байдлаар 66 анги, тасалгаатайгаас өагш нарын ажлын өрөө 25, лаборатори 18, дадлага семинарын 17, лекцын 5, магистр докторантын бие даалтын 1, оюутны зөвлөлийн 1, урлангийн танхим 1, эрдмийн зөвлөлийн 1 танхимтайгаар үйл ажиллагаа явуулж байна.
- ХААИС-ийн Захирлын 2017 оны 11-р сарын 30ны өдрийн А/159 тоот тушаалаар батлагдсан УХХЦҮ ахисан түвшний сургалтад магистрын зэрэг горилогч 33 цагийн багц цуглуулан суралцдаг байна.
- “Дээд боловсролын сургалтын байгууллагад тавих нийтлэг шаардлага”-ын дагуу УХХЦҮ хөтөлбөрт хамрагдах 4 лаборатори, семинар 3, бие даалтын 1 өрөө хамрагдан сургалтын орчин, нөхцөлд эрүүл ахуйн нөхцөл байдлын үнэлгээ хийгддэг.
- Жил бүр лабораториудын галын аюулгүй байдлын самбар, галын хорыг шинэчилж, бэлэн байдал, хэвийн ажиллагааг нь тогтмол хянадаг.
- 1 багшид 4.84 м², нэг оюутанд 6.2 м² талбай ноогдож байна.
- Ахисан түвшний судалгааны лабораториудыг төвлөрүүлсэн нь хөтөлбөрийн үнэ цэнэ нэмэгдэж суралцагсадад мэдлэг олгох бодит боломж бүрдүүлсэн.
- УХХЦҮ хөтөлбөрийн магистр бүр ХААИС-ийн интернетийн сүлжээнд холбогдож, цахим орчинд ажиллах нөхөцлөөр хангагдсан байна.
- 2016-2020 онуудад шинээр 11 өрөө тасалгааг шинээр тохижуулан, лаборатори анги тэнхимийн тохижилт хийгдсэн.
- Анги танхим лабораторийг сургалт судалгаанд зориулан тохижуулсан.
- Судалгааны ажлыг онол арга зүйн өндөр төвшинд гүйцэтгэж бодит үр дүн гаргаж бүтээлийг хамгаалдаг.
- ХААИС-ийн сүлжээнээс үнэ төлбөргүй ашиглах боломжтой цахим мэдээллийн сангуудын тоог жилээс жилд баяжуулж зөвшөөрөгдсөн ном, сэтгүүлүүдийг үнэ төлбөргүй ашиглах, мэдлэгийн хүрээгээ тэлэх боломжийг олгож байна.
- Дотоод, гадаад эх үүсвэрээс санхүүжигдсэн төсөл жил бүр нэмэгдэж байгаа.
- ХААИС, АЭС-ийн Таримал судлал, ой, ландшафтын архитектурын тэнхимийн харьяа Зайсангийн аманд байрлах 1.7 га талбай бүхий Агропарк ССҮТ
- Төв аймгийн Баянчандмань сумын Өргөн булгийн аман дахь 2 га мод үржүүлгийн сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн төвүүдэд УХХЦХҮ хөтөлбөрөөр суралцаж байгаа магистрантууд арга зүйн дагуу туршилт, судалгааны ажлаа хийж гүйцэтгэдэг.
- 2017 оноос ХААИС, Өмнөговь аймаг хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Даланзадгад хотод БНСУ-ын Кёнсанбуг аймгийн ХАА-технологийн хүрээлэн, Өмнөговь аймгийн ЗДТГ газар болон Говийн оюу сангаас 1,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүлэмжийн аж ахуйн цогцолбор”- байгуулсан

ба тус төвд магистрантуудыг туршилт судалгаа хийх нөхцөлөөр ханган ажиллаж байна.

- 2020 онд Хүлэмжийн аж ахуйн цогцолборт сургалт болон оюутны байр, лабораторийг барьж ашиглалтад оруулсан.

Анхаарах асуудал:

- Сургалтын байр хуучирсан, цахилгаан шугам сүлжээ муудсан, их засвар хийх шаардлагатай.
- Магистрын хөтөлбөрт ашиглагддаг зарим сургалтын лаборатори, анги танхимд урсгал засвар хийж аюулгүй байдлыг хангах шаардлагатай.
- Лабораторийн хичээлд ашигласан (химийн урвалж, бодис) материалыг тусгай зориулалтаар стандартын дагуу устгах нөхцөлийг бүрдүүлэх, аюулгүй байдлыг тогтмол хангахад анхаарах
- Лабораториудын тоног төхөөрөмжийг сайжруулах, шинэчлэхэд сургуулийн захиргааны зүгээс анхаарч, цаашид хөрөнгө оруулалт хийх тал дээр анхаарах
- Суралцах орчинд сэтгэл ханамж дунджаас дээгүүр байгаа ч суралцах орчин болон судалгааны лабораторийн багаж тоног төхөөрөмжийг шинэчлэлт, сайжруулалт хийх хэрэгтэй байна.

Зөвлөмж:

- Сургалтын орчинд тог цахилгааны шугамын засвар хийж аюулгүй байдлыг ханган стандартыг мөрдөх
- Лабораторийн хичээлд ашигласан (химийн урвалж, бодис) материалыг тусгай зориулалтаар стандартын дагуу устгах нөхцөлийг бүрдүүлэх, аюулгүй байдлыг тогтмол хангах
- Судалгааны төвүүдэд ажиллах оюутнуудад хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааварчлага өгөх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.2. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг хангалттай бүрдүүлж, судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, магистрантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн сурах бичиг, гарын авлага, цахим ном, эрдэм шинжилгээний өгүүлэл, сэтгүүлийн мэдээлэл, үйлчилгээний хүртээмж
- Уншлагын танхим, номын сангийн үйлчилгээ, хүртээмж

- Онолын болон лабораторийн хичээлд ашиглагдах материаллаг нөөц, биет үзүүлэн, тараах материал, видео болон хөдөлгөөнт хэрэглэгдэхүүний хүртээмж
- Сургалтын үйл ажиллагаанд шаардагдах сургалт, аюулгүй ажиллагааны заавар зөвлөмж, гарын авлага, хэрэглээ

Онцлог зүйл/Туршлага

- УХХЦХҮ хөтөлбөрөөр суралцагсад ХААИС-ийн төв номын сангаар болон сургалт, судалгааны төвүүд дэх номын сангийн ном сурах бичиг, магистр, докторын судалгааны ажил, CD-ээр үйлчлүүлдэг.
- “Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлага” /MNS5742:2019/ стандартад нийцүүлэн төв номын сан нь 200 гаруй суудалтай 3 уншлагын танхим, 20 гаруй суудалтай интернет танхим, нээлттэй-чөлөөт сонголттой уншлагын танхимуудтай
- Уншлагын танхимуудын үйлчилгээнд RFID-технологи нэвтрүүлснээр, уншигчид өөрт хэрэгцээтэй номоо тавиур дээрээс чөлөөтэй сонгох боломжтой, ном авахаар дараалалд зогсож цаг алдахгүй болж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, тав тухтай орчин бүрдсэн.
- 2001 оноос төв номын сангаас эхлэн гадаад, дотоод сүлжээг байгуулан номын сангийн цогц програмын Lib4U Net Version, 2010 оноос Lib4U Net Version 1.9.6, 2013 оноос **Lib4U Net Version 1.9.7** хувилбар, 2017 онд үүлэн технологи дээр суурилсан **Lib4U Net Version** шинэ хувилбарыг төв болон салбар номын сангуудад авч хэрэглэсэн.
- 2017 оноос “**Online library management system**” програмыг СБЗА-ний мэдээлэл технологийн мэргэжилтнүүдээр зохиолгон, уг програмыг ашиглан э-ном, э-судалгааны ажил, э-сэтгүүлийг магистрантуудад хүргэж ажилладаг.
- Онолын болон лабораторийн хичээлд ашиглагдах материаллаг нөөц, биет үзүүлэн, тараах материал, видео болон хөдөлгөөнт хэрэглэгдэхүүний хүртээмж хангалттай.
- 2016 оноос эхлэн Дэлхийд нэр хүнд бүхий “**Springer Nature**” цахим мэдээллийн санг төрийн өмчийн 6 их сургуульд БСШУСЯ, www.springerprotocols.com, www.link.springer.com цахим мэдээллийн сангуудыг ХААИС худалдан авч үйлчилгээндээ нэвтрүүлсэн.
- Цахим сургалтын үйл ажиллагааг зохицуулах ХААИС-ийн “Цахим сургалтын журам”-ыг 2020 оны 11 сарын 27-ний өдрийн А/167 тоот тушаалыг баталсан бөгөөд тус журмыг мөрдөн ажиллаж байна.
- УХХЦХҮ хөтөлбөрийн сургалтыг танхим болон зайн сургалтаар хослон явагдаж байна.
- Цахим сургалтын үйл ажиллагааг зохицуулах ХААИС-ийн “Цахим сургалтын журам”-ыг 2020 оны 11 сарын 27-ний өдрийн А/167 тоот тушаалыг баталсан бөгөөд тус журмыг мөрдөн ажиллаж байна.

- Хичээлийн стандарт хөтөлбөрт тусгагдсан агуулгыг бүрэн хамарсан эсэхэд МДС-ийн хөтөлбөрийн зохицуулагч, бүрэлдэхүүн сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирал, мэргэжлийн хөтөлбөрийн хорооны зохицуулагч болон тэнхимийн эрхлэгч хяналт тавин ажилладаг ба цахим сургалтын журмыг баримтлан хичээлийг шинэчлэх сайжруулах ажлыг хийдэг.
- Мэдээллийн технологийн хэрэгслийг профессор багш нар сургалтанд тогтмол ашиглаж хичээлд шаардлагатай үзүүлэн, бусад материалыг дэлгэцээр харуулах, цахим орчинд байршуулах зэргээр сургалтанд ашигладаг.
- Цахим ном, эрдэмтдийн бүтээлийг багш, оюутан, судлаачдын хүртээл болгох ажилд ахиц гарсан.
- Номын сан жил бүр ном сурах бичиг, сэтгүүлийг худалдан авч номын фондыг баяжуулдаг

Анхаарах асуудал:

- Сургалт, судалгааны лабораторит ашиглагддаг урвалж, бодис худалдан авах, материалын хангамжийг нэмэгдүүлэхтэй холбоотой зардлыг нэмэгдүүлэх тал дээр анхаарах
- Дадлагын хичээлд ашиглагддаг химийн урвалж бодисын жагсаалт гарган бүртгэлжүүлэх тусгаарлагдсан орчинд хадгалж аюулгүй байдал хангасан байх
- Сургалт, судалгаанд хэрэглэдэг ном ,сурах бичгийг шинчлэн, англи хэл дээр ашиглах ном, сурах бичгээр хангах

Зөвлөмж:

- Сургалтад ашиглах лабораторийн гарын авлага, сургалтын материалыг сургуулийн зүгээс нэгдсэн цахим хэлбэрээр бэлтгэн эдийн засгийн хэмнэлт хийн оюутнуудад хүртээмжтэй байдлаар ашиглуулах ажлыг бүрэн хэрэгжүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.3. Төсөв санхүүжилт.

Хөтөлбөр олон эх үүсвэрээс санхүүжих ба хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх,хяналт үнэлгээ хийх,шинчлэх төсөвтэй байна. Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Магистр оюутанд ноогдох зардал
- Ургамал хамгаалал хорио цээрийн хяналт үнэлгээ хөтөлбөрийн сургалтын төлбөрийн хэмжээ онуудаар
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо

- Мэргэжлийн хөтөлбөрийн багш нарын төсөл, хөтөлбөр, захиалгат ажил, гэрээт ажил удирдсан болон гүйцэтгэсэн байдал (сүүлийн 5 жилд)
- Мэргэжлийн хөтөлбөрийн багш нарын хэрэгжүүлсэн судалгааны төслийн өртөг дотоод төсөл 65.5 сая/төг (2016-2020), (гадаад төсөл \$ 4,1)

Онцлог зүйл/Туршлага

- Сургуулийн санхүүгийн үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа ба ХААИС-ийн санхүүгийн үйл ажиллагааны журмын дагуу УХХЦХҮ мэргэжлийн хөтөлбөрийн зардлыг санхүүжүүлдэг.
- УХХЦХҮ хөтөлбөр жил бүр элсэгчидтэй байдагтай холбоотой ХААИС-ийн төвшинд эдийн засгийн ашигтай ажилладаг хөтөлбөрт тооцогддог.
- Сургалтын төлбөрийг тооцохдоо дараах загварыг баримталдаг. Үүнд:100%= Хөрөнгө оруулалт (4.0%) +Сургалттай холбоотой шууд зардал (80.3%) + Сургалттай холбоотой шууд бус зардал (16%)
- БШУЯ-аас өгсөн чиглэлийн дагуу тухайн жилийн инфляцийн дундаж түвшинг харгалзан, ХААИС-ийн удирдах зөвлөлийн хурлаар тогтоодог байна.
- Сургалтын төлбөрт нэг магистрантад ногдох шууд ба шууд бус зардал оноор ялгаатай байдаг.
- Сургалтын төлбөрийг тогтоохдоо цалин, үндсэн хөрөнгө болон түүнтэй холбоотой хөрөнгө оруулалтын зардал, хичээл практикийн зардал, үйл ажиллагаатай холбоотой зардлыг оролцуулан тооцдог.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн санхүүгийн үндэс нь бусад төрийн өмчит их дээд сургуулиудын нэгэн адил сургалтын төлбөр байх бөгөөд санхүүгийн олон талт эх үүсвэрийг бий болгох зорилтын хүрээнд тус хөтөлбөрийн багш бүр төрийн ба төрийн бус байгууллагатай хамтын ажиллагаа өрнүүлэх замаар тодорхой хэмжээний санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг бий болгодог.
- Сүүлийн жилүүдэд экологид ээлтэй газар тариаланг хөгжүүлэх,органик тариаланг хөгжүүлэх, ургамал хамгааллын чиглэлээр Өмнөд Солонгос улсын КОЙКА, КОПИА-МОНГОЛ төв, Япон улсын ЖАЙКА ОУБ, Фрацын Жээрис ОУБ, АНУ-ын Глобал трайнинг центр, дотоодын БСШУЯамны ШУТсан, ХХААЯам болон бусад олон байгууллагуудтай хамтран олон улсын болон дотоодын захиалгат болон гэрээт төслийг хэрэгжүүлж төсөв зардалдаа хувь нэмэр оруулж байна.
- УХХЦХҮ хөтөлбөрт хамаарах багш нар өөрсдийн олсон төсөл хөтөлбөрүүддээ магистрант оюутнуудаа хамруулж судалгааны зардлыг гарган хийлгэдэг байна.
- Монгол улсын хэмжээнд 2019 оны 1-р сарын 01-нээс мөрдсөн “Багшийн хөгжлийг дэмжих тухай”, 2016 оны 6-р сарын 27-ний өдрийн хууль, ХААИС-ийн ректорын 2002 оны 11-р сарын 20-ний өдрийн 156 тоот тушаалаар “ Багшийн хөгжил” хөтөлбөр, Багшийн хөгжил хөтөлбөрийн бодлогын баримт бичгийг ХААИС-ийн тэнхимийн эрхлэгчдийн 2017 оны 02-р сарын 23-ний өдрийн тушаалаар сайшааж,захиргааны зөвлөлийн 2017 оны 03-р сарын 23-ний

өдрийн хурлаар батлагдсан баримт бичгийг ХААИС-ийн багшийн хөгжилд мөрдлөг болгон ажилдаг байна

- Хөтөлбөрийн багш нарын удирдаж буй дотоод, гадаадын төсөл хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн олон эх үүсвэрийг бүрдүүлж лабораторуудын багаж, тоног төхөөрөмж, болон анги танхим эрс сайжирч байгаа нь багш нарын оролцоо их байгааг харуулж байна.

Анхаарах асуудал:

- Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэхэд ХААИС болон бүрэлдэхүүний сургуулийн зүгээс энэхүү асуудлыг бодлогоор дэмжиж ажилладаг хэдий ч энэ хөтөлбөрт хичээл заадаг багш нарыг мэргэжлийн болон мэргэшүүлэх чиглэлээр нь тодорхой хугацаа, давтамжтайгаар дотоод болон гадаадын сургалтад хамруулах, Сургалтын төлбөрийн тодорхой хувийг сургуулиас гаргах
- Багш нарын 40 хувь нь тавиас дээш настай багш нар байгааг харгалзан залуу багш нарыг докторын зэрэг хамгаалуулах, тэднийг төлөвшүүлэн хөгжүүлж залгамж халааг бэлтгэхэд анхаарах

Зөвлөмж:

- Сургуулийн зүгээс багш, оюутны судалгааны ажлын үр дүнгээс мэргэжлийн нэр хүндтэй сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэх талд санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- Багш нарын сургалт судалгааны ачааллыг дахин тооцох, ачааллыг жигд хувиарлах, багасгах
- Төгсөгчдийн зүгээс санал болгож буй хүсэлт буюу мэргэшүүлэх төлбөртэй сургалтыг зохион байгуулж хөтөлбөрт зарцуулагдах төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Удирдлага мэдээллийн систем

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд нийцсэн засаглал ба удирдлагын тогтолцоотой, захиргааны зохистой бүтэц, удирдлагын мэдээллийн системтэй байна.

6.1. Засаглал ба удирдлага

Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах үр ашигтай засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэцтэй байх ба академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг байна.

Илрэл/ нотолгоо:

- Сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, хэтийн зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх ур чадвар бүхий удирдлагын чадварлаг, цомхон, бүтээлч, санаачилгатай баг бүрдүүлж ажилладаг.
- Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж нийгмийн хариуцлагатай оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг.
- УХХЦХҮ хөтөлбөрийн хороо нь ХААИС-ийн захирлын 2019 оны 03 сарын 26 өдрийн А/69 тоот тушаалаар батлагдсан бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.
- Магистрын хөтөлбөрийг боловсруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, аргазүйн болон чанарын удирдлагаар хангаж, хөтөлбөрийн хэрэгжилтийн чанар, үр дүнг хариуцаж тайлагнах (*Захирлын 2015 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/377 тоот тушаал*).

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн Магистр, докторын сургууль (МДС) нь 1997 онд Магистр, докторын сургалтын алба нэртэйгээр анх байгуулагдаж, 2004 оноос Магистр, докторын сургууль болж өргөжсөн.
- Мэргэжлийн хөтөлбөрүүдийн сургалтын төлөвлөгөөг хөтөлбөрийн хорооны хурлаар, дараа нь бүрэлдэхүүний сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж протоколын хамт МДС-ийн сургалтын албаруу явуулж ХААИС-ийн захирал баталдаг тогтолцоотой.
- Мэргэжлийн ахисан түвшний хөтөлбөрүүд нь МДС-д харьяалагддаг босоо удирдлагатай.
- МДС нь магистрын сургалт, судалгааны ажлыг нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, хөтөлбөрт оролцогч талуудын уялдаа холбоо, холбогдох чиг үүргийг удирдлагаар хангаж ажилладаг.
- МДС нь магистр, докторын сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, нэгдсэн шалгалт болон магистр, докторын ажлын хамгаалалтыг зохион байгуулах, холбогдох мэдээллийн сан бүрдүүлэх үүрэгтэй.
- УХХЦХҮ хөтөлбөрийн хороо нь ХААИС-ийн захирлын 2019 оны 03 сарын 26 өдрийн А/69 тоот тушаалаар батлагдсан бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг.
- УХХЦХҮ мэргэжлийн чиглэлээр ТСОЛАТ-ийн “Ургамал хамгаалал” профессорын багаар нийт 4, “Биологийн нөөц, таримлын технологийн хөгжил профессорын багаар нийт 8 магистрантын арга зүй тус тус баталсан.
- Магистрын сургалтын үйл ажиллагаа нь БШУ-ны сайдын Магистр, докторын сургалт эрхлэх журам (*2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хэвсрэлт*), Захирлын 2014 онд батлагдсан ХААИС-ийн Магистр, докторын сургалтын журам болон бусад холбогдох дүрэм, журмаар зохицуулагдаж байна.

- Мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлэгч боловсон хүчин, материаллаг орчин нөөц бүрдсэн.
- Сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хослон явуулж ирсэн уламжлалтай, туршлагатай.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн чанарын удирдлага, хяналтын систем бүрэн хөгжөөгүй
- Удирдлагын мэдээллийн системийн үйл ажиллагаанд хэрэглэж буй технологи, программ хангамжийг байнга сайжруулах
- Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдалд технологийн хөгжлийг ашиглах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хөгжүүлэхэд олон улсын байгууллага, олон нийтийн туслалцаа дэмжлэг авах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.2. Ажилтнууд

ХААИС-ийн магистрын сургалт, судалгааны ажлыг нэгдсэн зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг Магистр, докторын сургууль (МДС) удирдлагаар хангаж ажилладаг.

Илрэл/ нотолгоо.

- ХААИС-ийн МДС -ийн бүтэц бүрэлдэхүүн
- МДС –ийн ажлын үүрэг

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС –ийн МДС –ийн бүтэц бүрэлдэхүүн
- МДС-ийн захиргааны болон туслах ажилтан нь Боловсрол судлалын магистр болон бусад шинжлэх ухааны салбарт нарийн мэргэшсэн доктор, профессор зэрэгтэй, улсад олон жил ажилласан туршлагатай боловсон хүчин бүрдэн ажилласан.
- МДС-ийн захиргааны болон туслах ажилтан нь мэдлэг боловсролоо дээшлүүлэх, ахисан түвшинд дэвшин суралцахад ХААИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын 6.7.2, 7.1.9-р зүйл; захиргаа үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээний 2.21-д заасан заалтыг үндэслэн магистр, докторын сургалтын төлбөрийг хөнгөлүүлэн суралцах бүрэн боломжтой

Анхаарах асуудал.

- Захиргааны болон туслах ажилтан орчин үеийн мэдээлэл технологи эзэмших, программ эзэмших чадвар дээшлүүлэх

- Хөтөлбөрийн чанарын удирдлага, хяналтын систем дээр анхаарах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3 Удирдлагын мэдээллийн систем. Хөтөлбөрийн удирдлагын шуурхай, оновчтой, үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байна. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашиглана.

Илрэл нотолгоо:

Цахим-сургалт-ыг хэрэгжүүлэх, хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтэд **ONEMIS** (Их Дээд Сургуулийн удирдлага мэдээллийн систем), **Eliademy** (Зайн сургалтын систем) зэрэг цахим программуудыг ашиглаж байна

- Сургалтын албаны программ
- Хүний нөөцийн программ
- Сургалтын төлбөрийн программ
- Онлайн тестийн дэд систем
- Номын сангийн программ
- Эрдэм шинжилгээний систем
- Тайлангийн нэгдсэн систем
- Байгууллагын тоо бүртгэлийн ажилтнуудад зориулагдсан программ.

Онцлог зүйл/Туршлага:

- Орчин үеийн технологи ашигласан, хэрэглэгч ашиглахад хялбар энгийн.
- Монгол улсын онцлогт тохирсон. Кредит болон ангийн системээр сургалт явуулж буй бүх сургуулиудад ашиглах боломжтой, уян хатан ажиллагаатай
- Дотоод сүлжээний интернет, интернетийн орчинд ажиллахаар боловсруулагдсан
- Салбар сургуулиудтай болон бүх их, дээд сургуульд ашиглах бүрэн боломжтой
- Суралцагчдын элсэн орохоос эхлэн төгсөх хүртэлх сурлагын үзүүлэлт, төлбөрийн болон бусад дагалдах мэдээллийг цогц байдлаар бүрдүүлэн суралцагчдыг төгсгөх
- Дипломын хавсралтыг хэвлэн гаргах үйл ажиллагаа бүгд автоматжуулагдсан.
- Программ дэд системүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - Сургалтын албаны программ: Сургалтын албаны ажилтнуудын өдөр тутам хийж гүйцэтгэгддэг бүх ажлууд энэхүү программд тусгагдсан бөгөөд суралцагчтай холбоотой үндсэн мэдээлэл, шилжилт, хөдөлгөөн гэх мэдээлэл оруулах, хичээл сонголт, дүнгийн нэгдсэн бүртгэл, хайлтыг хийнэ.

- Хүний нөөцийн программ: Сургуульд ажиллаж байгаа багш, ажилтны мэдээллийг боловсруулах бөгөөд сургуулийн хүний нөөцийн ажилтнуудад зориулагдсан
- Сургалтын төлбөрийн программ: Суралцагчийн мэдээлэл, төлбөрийн үлдэгдлийн мэдээлэл авах бөгөөд суралцагчийн хичээлийн сонголтын товчоо буюу суралцагчийн кредитийн товчоог дамжуулна
- Онлайн тестийн дэд систем: Программ нь суралцагчдын судалж буй хичээлээр шалгалт авахад зориулагдсан систем бөгөөд тест өгөх, тест оруулах
- Номын сангийн программ: Номын сангийн цогц програм хангамж бөгөөд олон салбартай томоохон номын сангуудад зориулсан систем бөгөөд бие даан ажиллах боломжтой систем
- Эрдэм шинжилгээний систем: Сургуулийн эрдмийн зөвлөлөөс явагдаж буй бүх үйл ажиллагааг мэдээлэл хүргэх бөгөөд суралцагчдын мэдээлэл болон эрдэм шинжилгээний хурал, семинар, сургалтууд, эрдэм шинжилгээний төслүүд гэх мэт мэдээллийн нэгтгэдэг
- Тайлангийн нэгдсэн систем: Программ нь мэдээллийн нэгдсэн сангаас удирдах дээд байгууллага болон сургуулийн дотоод хэрэгцээнд зориулагдан гарах статистик тоо бүртгэлийг гаргах зорилготой. Байгууллагын тоо бүртгэлийн ажилтнуудад зориулагдсан программ

ОЮУТНЫ ПРОГРАММ

Шинээр элсэгч оюутан бүрд өөрийн код, нууц үг бүхий оюутны программаар нэвтрэх эрхийг сургалтын алба өгөх ба программыг хэрхэн ашиглах зааварчилдаг. Энэхүү оюутны программ нь суралцагчдын элсэн орохоос эхлэн төгсөх хүртэлх сурлагын үзүүлэлт, төлбөрийн болон бусад дагалдах бүх мэдээллийг цогц байдлаар бүрдүүлсэн. Мөн суралцагч нь оюутны программаар дамжуулан хичээл сонголтыг хийж сургалтын албаны ажилтанд илгээдэг.

БАГШИЙН ПРОГРАММ

Багшийн заах хичээлд суух оюутны мэдээлэл, хичээлийн хуваарийг дамжуулах бөгөөд багшийн заах хичээлийн мэдээлэл болон суралцагчдын дүнгийн мэдээллийг оруулах, татаж авч хэвлэх үйлдэлтэй.

Анхаарах асуудал:

- Удирдлагын мэдээллийн системийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй технологи, программ хангамжийн хүчин чадал, ашиглалтад дүн шинжилгээ хийж байх
- Захиргааны болон туслах ажилтны мэдээлэл, технологи эзэмших, хэрэглэх чадварыг дээшлүүлж, сургалтад хамруулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн системтэй байгаа ч цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээг хөтөлбөрийг сайжруулахад ашигладаг байх хэрэгтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.4. Мэдээллийн ил тод байдал ХААИС-ийн МДС-ийн graduateschool.muls.edu.mn албан ёсны вэб сайт нь олон талт үйл ажиллагааны өргөн мэдээлэлийг үндсэн ба туслах цэсээр ангилан түгээдэг байна.

Илрэл нотолгоо.

- Вэб сайтын холбоосуудаар Бүрэлдэхүүн сургууль, Харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, Багшийн программ, Оюутны программ, Номын сан, Элиадеми-Зайн сургалтын системрүү шууд холбогддог.
- Багш, оюутан болон бусад хөтөлбөрийн оролцогч талуудад мэдээллийг нээлттэй ил тод байдлаар хүргэх хүрээнд сургуулийн веб сайтыг тогтмол ажил ажиллуулдаг байна.
- Сургуулийн веб сайтад дараах үндсэн мэдээллийг тусгасан байна.

Сургалт

Эрдэм шинжилгээ.

Гадаад харилцаа.

Дүрэм журам

Элсэлт

Холбоо барих МДС-ийн утасны дугаар, мэйл хаяг, албан ёсны веб хуудасны хаяг байрласан байна.

Онцлог зүйл/Туршлага:

- МДС-ийн эрхэм зорилго, түүхэн замнал, эрдэмтдийн танилцуулга болон МДС-ийн холбогдох албан тушаалтны мэдээлэл, холбоо барих цахим хаяг, утасны дугаар зэрэг мэдээлэл байх ба дараах дэд цэсүүдтэй. (Түүхэн товчоо, эрхэм зорилго, манай эрдэмтэд, сургуулийн хаяг)
- **Сургалт.** Магистрын сургалт, Докторын сургалт гэсэн дэд цэстэй. Магистрантурын сургалт явуулах хөтөлбөрүүдийн нэр, индекс зэрэг үндсэн мэдээлэл байна. (Эрдэм шинжилгээ, гадаад харилцаа)
- **Дүрэм журам.** Магистрын сургалттай холбоотой дүрэм журмыг харах болон татаж авах боломжтой
- **Элсэлт.** Магистрын сургалтын хөтөлбөрт элсэхийг хүсэгчдийн бүрдүүлэх баримт бичиг, элсэгчдэд тавих шаардлага, элсэлттэй холбоотой мэдээлэл

авах бол холбогдох утасны дугаарыг энэ цэснээс харах боломжтой. (Магистр, докторын элсэлт, төгсөгчид гэсэн дэд цэсүүдтэй.)

- **Холбоо барих.** МДС-ийн утасны дугаар, мэйл хаяг, албан ёсны веб хуудасны хаяг байрлана.

Дээр дурдсан үндсэн цэсүүдээс холбогдох мэдээлэл авахаас гадна магистр оюутанд шаардлагатай татаж авах файлуудыг мөн байрлуулсан байдаг. Үүнд:

- Элсэгчийн анкет

- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө

- Санал болгох судалгааны сэдэв

- Удирдагчаар ажиллах зөвшөөрлийн хуудас

- Хамгаалалтад ороход бүрдүүлэх материалын жагсаалт

-Тойрох хуудас

- Багшийн цагийн тооцооны хуудас

- Веб хуудсанд байрлах чухал холбоосоор ХААИС-ийн Номын санд нэвтэрч болох бөгөөд 69.539 төрлийн, 183.463 ширхэг материал бүртгэгдсэн электрон каталог <https://muls.lib4u.net/> -ээс хэрэгцээт ном, сурах бичиг, гарын авлага, бакалавр болон ахисан түвшний ажил, автореферат, аудио видео материал зэргийг шүүж харах боломжтой байна.
- Холбоосоор дамжин бусад Их, дээд сургууль, дунд сургууль болон зарим аймгуудын номын сангийн электрон каталогуудруу нэвтрэх боломжтой
- **ХААИС, Магистр, докторын сургууль** нэртэй фэйсбүүк хаягыг <https://www.facebook.com/groups/454077664989176> тогтмол ажиллуулан хичээл болон шалгалтын хуваарийг нийтлэх, магистрын сургалттай холбоотой мэдээлэл, зарыг түгээхээс гадна эрдэм шинжилгээ эрхэлсэн захирал, хөтөлбөрийн хорооны зохицуулагчаар дамжуулан магистрант оюутнуудад мэдээллийг түгээдэг байна.

Анхаарах асуудал:

- МДС-ийн веб сайт, фэйсбүүк хуудасны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцсан мэдээлэл технологийн ажилтан байхгүй цаашид программист (IT) инженерийн мэргэжилтэнтэй болох
- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдал түүнд мэдээллийн технологийн хөгжлийг ашиглах байдалд анхаарах

Зөвлөмж:

- Ургамал хамгаллын чиглэлийн боловсрол, түүний нийгэм дэх ач холбогдолын ойлголтыг нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод болон хөндлөнгийн чанарын баталгаажуулалтын тогтолцоотой байна.

7.1. Чанарын дотоод баталгаажуулалт ба хөтөлбөрийн сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн Чанарын удирдлага зохион байгуулалтын албаны бүтэц
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем.
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИСургууль 2014 онд бүтцийн өөрчлөлтөөр Бодлогын мониторинг, үнэлгээ хөгжлийн албыг татан буулгаж, хяналт шинжилгээний мэргэжилтэн гэсэн 1 орон тоо
- 2015 онд аудит
- 2016 онд хяналт шинжилгээ, чанар хариуцсан мэргэжилтний орон тоог нэмснээр 3 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан
- 2018 оноос Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд Хөдөө аж ахуйн их сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ болон бусад холбогдох чиглэлийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах зорилгоор Чанарын удирдлага, зохицуулалтын албыг байгуулан ажиллаж байна.
- Алба нь бүрэлдэхүүний сургууль, алба, төв, нэгжүүдийн үйл ажиллагаанд үр дүнд суурилсан чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжилтийг хангах, сургалт, судалгаа, дотоод, гадаад хамтын ажиллагаа, санхүү, захиргаа, удирдлагын бүх үйл ажиллагаанд чанарын дотоод баталгаажуулалт, чанарын хяналт шинжилгээ хийх; хүний нөөцийн оновчтой бодлого менежментийг боловсруулж, хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг явуулдаг
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төлөвлөх, хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх асуудлыг ХААИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын алба хариуцдаг

- Хөдөө аж ахуйн их сургуулийн хөтөлбөрийн хорооны журам, (ХААИСургуулийн 2015 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/377 тоот тушаал)

Агроэкологийн сургуулийн захирлын

- 2014 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/62 тоот тушаал,
- 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/36 тоот тушаал,
- 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/115 тоот тушаал,
- 2019 оны 12 дугаар сарын 04-ний А/136 тоот тушаал)
- Чанарын удирдлага, зохицуулалтын алба байгуулах (ХААИС-ийн захирлын 2018 оны Б/283 тоот тушаал)
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИСургууль, СБЗАлба, Хөтөлбөрийн чанарын менежментийн гарын авлага. 2020 он гаргасан
- Сэтгэл ханамжийн үнэлгээ (суралцагч, төгсөгч)
- Төгсөгч оюутны сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ
- Явцын үнэлгээ судалгаа
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны ажлын тайлан
- Ажил олгогчын судалгаа авч чанараа үнэлж хэвшсэн
- Үр нөлөөний үнэлгээ(мэргэжлийн Салбар дахь нөлөөллийг үнэлэх)
- Дээрх судалгаа төгссөн мэргэжилтэн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад бүрэн хангаж байгааг харуулж байна.

Анхаарах асуудал:

- Чанарын дотоод баталгаажуулалтын журам, хөтөлбөрийг тодорхой болгох
- Хөтөлбөрийн чанарыг сайжруулахад оролцогч талуудын саналыг тусгах
- Сургалтын үйл ажиллагаанд виртуал орчинг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Цаашид тус хөтөлбөрийн элсэлтийн тогтвортой байдал дээр анхаарах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

7.2. Чанарын хөндлөнгийн үнэлгээ ба магадлан итгэмжлэл

Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт үнэлгээ магистр, докторын сургалтын хөтөлбөрт чанарын хөндлөнгийн үнэлгээг хөтөлбөрийн хорооны хяналтын гишүүн

хийхээр зохицуулсан байдаг. Хичээлийн үйл явцад хөндлөнгийн үнэлгээг Магистр, докторын сургуулийн хөтөлбөрийн эрхлэгч, хөтөлбөрийн хорооны зохицуулагч хяналт тавьж ажилладаг.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн үйл явцад хийх хөндлөнгийн үнэлгээ Магистр, докторын сургуулийн хөтөлбөрийн эрхлэгч, хөтөлбөрийн хорооны зохицуулагч хяналт тавьдаг.
- Хөтөлбөрөөр гадаадын их дээд сургуулийн ахисан түвшинд суралцагч оюутны судалгаа (суралцагч оюутны сурдаг үнэн тодорхойлолт, төгссөн оюутны дипломын хуулбар) хийдэг.

Онцлог зүйл/Туршлага:

- 2021 оны байдлаар 25 төгсөгч гадаадын их, дээд сургуульд элсэн, 6 доктор, 8 магистр төгсөж, 7 оюутан доктронтурт, 3 оюутан магистрант амжилттай сурч байна.
- Хөтөлбөрийн үр дүнг ажил олгогч, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, хөдөлмөр эрхлэлтийн талаар судалгаа авч дүгнэн ажиллаж байна. Судалгаанаас харахад төгсөгчдийн 72.3 % нь мэргэжлээрээ ажиллаж байгаа нь сургалтын хөтөлбөр үр дүнгээ өгч буйг харуулж байна.
- Ажил олгогч нийт 6 байгууллагын 24 хүнээс судалгаа авч үр дүнг боловсруулан дүгнэхэд төгсөгчийн ерөнхий мэдлэг, чадвар дунд 52%, түүнээс дээш үнэлгээг 42%, мэдлэг, чадвар үзүүлэлтээр дунд 42%, түүнээс дээш үнэлгээгээр 53% үнэлжээ. Энэ нь манай төгсгөн гаргаж байгаа мэргэжилтэн хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад бүрэн хангаж байгааг харуулж байна.

Анхаарах асуудал:

- Чанарын хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрэн хэрэгжүүлэх.
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөрийг тодорхой болгох

Зөвлөмж:

- Сургууль чанарын удирдлагын тогтолцооны стандарт (ISO 9001) “Чанарын менежментийн тогтолцоо” нэвтрүүлэх (estandard.gov.mn)
- Олон улсын хэмжээнд хөтөлбөрийн өрсөлдөх чадварыг ахиулах төлөвлөгөө гаргаж, тодорхой үр дүнд хүрч ажиллах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН.

ДҮГНЭЛТ

Монгол улын хэмжээнд ХААИС-ийн Агроэкологийн сургуулийн ТСОЛА-ийн тэнхимд харъяалах УХХЦХҮ хөтөлбөр нь ургамал хамгааллын салбарт магистрантурын сургалт явуулдаг цорын ганц хөтөлбөр, 20 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаа явуулж, нийт 90 магистр зэрэгтэй мэргэжилтэнг бэлтгээд байна. Бид өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримтуудыг судлан шинжилж, оролцогч талуудын уулзалтын үр дүнд дараах зүйлсийг дүгнэж байна. Үүнд:

1. УХХЦХҮ хөтөлбөр нь оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцсэн мэдлэг, ур чадвар олгох зорилгоо биелүүлсэн хөтөлбөр бөгөөд 2001 оноос хойш тогтмол сургалтын үйл ажиллагаа явуулж энэ хугацаанд 5 удаа (2003, 2009, 2011, 2015, 2017) шинэчлэн сайжруулсанаас үзэхэд энэхүү хөтөлбөр нь тасралтгүй хөгжиж ирсэн. иж бүрэн боловсруулагдсан хөтөлбөр, 2015 оны хөтөлбөрийн шинэчлэлтээр хөтөлбөрөөр олгох мэдлэг, ур чадвар бүрэн шинэчлэгдэж хичээлийн бүрийн агуулгад шингэснээрээ онцлог, давуу талтай хөтөлбөр болж, зори хангасан гэж дүгнэж байна.
2. УХХЦХҮ мэргэжлээр бакалаврын зэрэг төгсөгчдөөс цаашид үргэлжлүүлэн магистрын хөтөлбөрт суралцах хүсэлтэй оюутан цөөнгүй байдгаас гадна элссэн оюутнуудыг 2016-2020 оноор авч үзвэл жилд 6-19 оюутан элссэн байгаагаас үзэхэд харьцангуй тогтмол элсэлттэй хөтөлбөрт багтдаг, УХХЦХҮ-ний магистрын хөтөлбөрт элсэгчдэд суралцах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор танхимын болон онлайн сургалтын аль ч хэлбэрээр суралцах боломжийг элсэгчдэд олгох, суралцагчдыг төсөл хөтөлбөрийн хүрээнд судалгааны ажил хийлгэх, цалин урамшуулал олгох, ЭШ-ний хуралд илтгэл тавиулах, бүтээлийг нь хэвлэн нийтлүүлэх зэргээр магистрантын судалгаа, бүтээлч ажлыг дэмжин ажилладаг бөгөөд энэхүү хөтөлбөрөөр суралцагч магистрантуудын 3 судалгааны ажил 2017-2019 ондуудад дараалан ХААИС-ийн магистрант, докторантуудын ЭШ-ний бага хурлаас "Шилдэг илтгэл" -ээр шалгарч байсан.
3. Суралцахуйн үр дүнг сайжруулахын тулд суралцагчдын дунд санал асуулгыг жилд 2 удаа явуулж үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд судалгааны үр дүнгээс үзэхэд суралцагчдын хувьд эрдэм шинжилгээний удирдагчийн үйл ажиллагааг маш сайн гэж үнэлсэн бол эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирлын үйл ажиллагааг сайжруулах, төлөвлөх шаардлагатай гэсэн байв.
4. Элсэгчдийн тоог нэмэгдүүлэх, суралцагчдыг суралцахуйн зорилтоо биелүүлэхэд нь дэмжлэг болгож, боловсролын зээлийн сангаас сургуульд зохих журмын дагуу элссэн, сурлагын шаардлага хангасан, ирээдүйн зорилгоо тодорхойлсон суралцагсдад хүүгүй, барьцаагүй, хамтран зээлдэгчгүй, урт хугацаатай зээлийг олгож байгаа нь суралцах таатай

нөхцөлийг бүрдүүлснээс гадна профессор багш нарын төслөөс цалинжуулах, шилдэг илтгэлийн мөнгөн урамшуулал (500.0-1000.0 төгрөг) олгох зэргээр дэмжлэг үзүүлдэг.

5. УХХЦХҮ хөтөлбөрт харьяа тэнхимийн профессор, багш нараас гадна мэргэжлийн хүрээлэнгийн эрдэмтэд багшилдаг, хүний нөөцийн хувьд бүрэн хангагдсан, 100% докторын зэрэгтэй, ахлах зэргээс дээш албан тушаалд ажилладаг профессор, багш нартай хөтөлбөр бөгөөд профессор, багш нар нь олон төсөл, хөтөлбөрүүдийг удирддаг, гүйцэтгэдэг учраас элсэгчдийг эрдэм судалгааны ажилд татан оролцуулдаг зэргээр суралцагчдыг тогтмол дэмжин хөгжүүлдэг болно.
6. УХХЦХҮ хөтөлбөрт хичээл заадаг багш нарыг чадавхижуулах, заах арга, судалгааны арга зүйг сайжруулах, магистр оюутны хэрэгцээнд нийцсэн сургалт, судалгаа явуулахад чиглэсэн сургалт, төслийг хэрэгжүүлэн, анхаарч ажилладаг бөгөөд үүний үр дүнд УХХЦХҮ хөтөлбөрт заагддаг нийт хичээлийн 40% нь Европын Холбооны дээд боловсролыг сайжруулах төслийн хүрээнд шинэчлэгдэн сургалт, заах арга зүйн хувьд сайжруулагдаж, англи хэл дээр заагдах боломжтой болохоор ажиллаж байна.
7. Сургалт, судалгааны орчныг эрүүл, аюулгүй, тохилог орчин бүрэлдсэн, ургамал хамгаалын чиглэлийн судалгаа хийх лаборатори, хээрийн судалгааны сургалтын баазтай бөгөөд энэхүү хөтөлбөрөөр элссэн магистрантууд нь биеэ дааж судалгаа хийх орчноор хангагдсан, мөн удирдагч профессор багш нарын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт хамрагдан судалгааны ажлаа идэтгэх, бүтээлээ хэвлэн нийтлүүлэх боломжтой байдаг.
8. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагааг боловсронгуй болгох үүднээс сургууль, мэргэжлийн хөтөлбөрийн хороо байгуулагдан хөтөлбөрийн үйл ажиллагааг шат дараалан явуулж, сургалтанд оролцогсодоос сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авч үйл ажиллагаандаа тустгадаг болсон нь хөтөлбөрийг хөгжүүлэхэд ахиц дэвшил болжээ.
9. УХХЦХҮ хөтөлбөрөөр суралцагч магистрант нь Агроэкологийн сургуулийн харьяа Нарт, Өнжин, Агропарк сургалт судалгааны төвүүдэд судалгаа хийх боломжтойгоос гадна УХЭШХ, МХЕГ-ын лабораториудад судалгааны ажлыг гүйцэтгэх боломжтой, тус хөтөлбөрөөр суралцаж төгсөгчид нь суралцах хугацаандаа онол, практикийн мэдлэгийг хангалттай эзэмшиж чадварлаг мэргэжилтэн болон төгсөж байгаа учраас БНСУ, БНХУ, Болгар, Унгер, Япон, Австрали, ОХУ зэрэг дэлхийн 10 гаруй оронд ахисан түвшинд суралцаж

байгаагаас энэхүү хөтөлбөр нь цаашид ОУ-ын жишиг хангах боломжтойг илтгэж байна.

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга	+			
2	Магистрын хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	+			
3	Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	+			
4	Багшлах бүрэлдэхүүн	+			
5	Нөөц ба санхүүжилт	+			
6	Удирдлага ба мэдээллийн систем	+			
7	Чанарын баталгаажуулалт	+			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ХААИС, Магистр, докторын сургуулийн “Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт, үнэлгээ” E08110104 магистрын хөтөлбөрийг БМИУЗ-ийн Магистрын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх шалгуур шаардлагад нийцэж байгаа тул ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Д.Оюунцэцэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Н.Цагаанцоож

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Я.Гэрэлчулуун

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Магистрын хөтөлбөрийн зорилго, агуулга	<ul style="list-style-type: none"> ➤ Ажил олгогч болон төгсөгчдийн саналыг харгалзан үзэж хөтөлбөрт мэргэжлийн англи хэл, статистик, молекул биологи, мэргэжлийн ой, ойн нөхөн сэргээлтийн хичээлийг илүү гүнзгийрүүлэн оруулах, хорио цээрийн болон хил гаалийн хууль эрх зүйн хичээлийг сонголтоор оруулах нь зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах нэгэн үзүүлэлт болно. ➤ Хөтөлбөр боловсруулахдаа оюутанд олгох мэдлэг чадвар дадлыг хичээл, сэдэв бүрээр алхамчлан дэлгэрэнгүй болгон боловсруулах. ➤ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй ажиллах чадвар дадал эзэмшүүлэхэд анхаарах.
Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийн оюутнуудад зориулсан тусгайлсан чиглүүлэх сургалтыг бий болгон хэрэгжүүлж оюутнууд өөрийн мэргэжлийн онцлог давуу талыг мэдрэхэд нь түлхүү анхаарч ажиллах ➤ Хамтын ажиллагааны гэрээтэй байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй сургалт болон үйлдвэрлэлийн дадлага хамтран явуулахаас гадна уг хөтөлбөрөөр элсэн суралцагсдад чиглэсэн мэргэжлийн зөвлөх үйл ажиллагаа, төгсөгчдөд ажлын байр бий болгох талаар хамтран ажиллах
Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил	<ul style="list-style-type: none"> ➤ Оюутнуудын авсан үнэлгээнд суурилсан харьцуулсан анализ хийж, суралцахуйн үнэлгээг сайжруулах. ➤ Төгсөгчдийн голч дүнгийн түвшинг ахиулах улмаар сургалтын чанарыг нэмэгдүүлэх.
Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> ➤ Судалгааны ажлын үр дүнг олон улсын “Web of science”, “Scopus”-тай сэтгүүлд хэвлүүлэх талаар багш нарыг дэмжих ➤ Судалгааны үр дүнгээр олон улсын сэтгүүлд хэвлэгдсэн өгүүлэлийн мэдээлэлийн сан байгуулж ажиллах

	<ul style="list-style-type: none"> ➤ Англи хэл дээр хэвлэгдсэн, хамгийн сүүлийн үеийн сурах бичигтэй болох. ➤ Багшийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах (өрөө, ширээ, сандал, компьютер, судалгааны лаборатори, багаж төхөөрөмж).
Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт	<ul style="list-style-type: none"> ➤ Төгсөгчдийн зүгээс санал, хүсэлт болгож буй мэргэшүүлэх төлбөртэй сургалтыг зохион байгуулж, хөтөлбөрт зарцуулагдах төсөв санхүүгийн үүсвэрийг нэмэгдүүлэх ➤ Төгсөгчдийн холбоог байгуулж үйл ажиллагааг өргөжүүлэн, тэдний нөөц, чадавхийг хөтөлбөрийн хөгжилд чиглүүлэн хамтран ажиллаж тус хөтөлбөрөөр элсэн суралцагсдын тоог нэмэгдүүлэх ➤ Хөтөлбөрийн элсэлтийн менежментийг сайжруулан элсэлтийн тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарах
Шалгуур 6. Удирдлага ба мэдээллийн систем	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийн зорилгодоо хүрэхэд туслах засаглал, удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэц байгаа ч энэ удирдлагын тогтолцоо, захиргааны бүтэц нь хөтөлбөрийн гишүүдийн академик эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг дэмждэг шаардлагыг хангасан байх ➤ Удирдлагын мэдээллийн системтэй ч цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж хөтөлбөрөө сайжруулахад ашигладаг байх . ➤ Хөтөлбөртэй холбоотой үнэн зөв мэдээллийг багш, оюутнуудад нээлттэй ил, тод хүргэдэг байх ➤ МДС-ийн хөтөлбөрийн удирдлага, мэдээллийн системд хэрэглэгдэж буй программ хангамжийг жил бүр сайжруулж хүчин чадлыг нэмэгдүүлэн цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийж хөтөлбөрт хэрэглэх боломжийг нэмэгдүүлэх
Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ УХХЦХҮнэлгээ магистрын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт бүрэн бүрэлдээгүй, хийгдэж байгаа тул чанарын дотоод баталгаажуулалтын журам, хөтөлбөрийг тодорхой болгох ➤ Хөтөлбөрийн чанарын төлөвлөлт, хяналт, үнэлгээний шинэ механизм боловсруулж хэрэгжүүлэх

	<p>➤ Чанарын баталгаажуулалт хийхийн тулд сэтгэл ханамж, явц, үр нөлөө үнэлгээний судалгааны үр дүнд боловсруулалт хийж хөтөлбөрөө сайжруулахад бүрэн ашиглах хэрэгтэй.</p>
--	---

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	ОВОГ НЭР	ЗААДАГ ХИЧЭЭЛ	АЖЛЫН БАЙР	ЕМАЙЛ	УТАС
1	Г.Туяагэрэл	Судлаачийн ес зүй	ХААИС, багш	tuyagerel@muls.edu.mn	
2.	Б.Баярмаа	Судалгааны ажлын төлөвлөлт, бүтээл бичих	ХААИС, ШУЗ, ЭНБД	bayarmaa_iao@muls.edu.mn	88020031
3.	Б.Одгэрэл	Хээрийн судалгааны арга зүй	ХААИС, багш	odgerel_agro@muls.edu.mn	99275018
4.	Д.Ундармаа	УХЦА-ын менежмент	ХААИС, багш	undarmaa@muls.edu.mn	99108034
5.	Н.Дамбадаржаа	Хөрс судлал	ХААИС, багш	n_dambadarjaa@muls.edu.mn	99048471
6.	О.Мөнхжаргал	Тогтвортой газар тариалангийн систем	ХААИС, багш	munkhjargal_agro@muls.edu.mn	99904907
7.	Д.Насандулам	Шавжийн судалгааны аргууд	ХААИС, багш	nasandulam@muls.edu.mn	99005401
8.	Д.Ундармаа	Ургамлын өвчний судалгааны аргууд	ХААИС, багш	undarmaa@muls.edu.mn	99108034
9.	Б.Батдэлгэр	Таримал ургамлын судалгааны аргууд	ХААИС, багш	batdelger@muls.edu.mn	99890194
10.	Д.Хандсүрэн	Ургамлын физиологийн судалгааны аргууд	ХААИС, багш	khandsuren@muls.edu.mn	99089943
11.	Б.Энхжаргал	Ургамлын өвчин, хортны прогноз	ХААИС, багш	benkhjargal@muls.edu.mn	89899757
12.	Д.Банзрагч	Пестицидийн токсикологи, метаболизм	ХААИС, багш	banzragch@muls.edu.mn	89902901
13.	Т.Уламбаяр	Молекул биологийн судалгааны аргууд	ХААИС, багш	banzragch@muls.edu.mn	99179536
14.	Д.Банзрагч	Хүрээлэн буй орчны эрсдлийн үнэлгээ	ХААИС багш	banzragch@muls.edu.mn	ХААИС, багш
15.	Н.Энхболд	Мэрэгч амьтны судалгааны аргууд	УХЭШХ ЭШТА	enkhbold.nanj@yahoo.com	99194073
16.	Ю.Хорлоо	Хүрээлэн буй орчны микробиологи	ХААИС багш	khorooyundendorj@gmail.com	99017582

II. Оюутны нэрс

№	ОВОГ НЭР	АЖЛЫН БАЙР	ЕМАЙЛ	УТАС
1	Г.Энхбулган	магистрант	УХЭШХ тус.ажилтан	99193310
2.	Б.Буян	магистрант	buyan_95@yahoo.com	99615245
3.	Х.Хулан	магистрант	Hulaka87@gmail.com	95651215
4.	А.Сийриймаа	магистрант	AG20E003@muls.edu.mn	80856001
5.	Б.Энхжаргал	магистрант	Enkhjargal.ipp@gmail.com	99667871
6.	Д.Номиндалай	магистрант	nomindalai.damdinsuren88@gmail.com	90076918
7.	А.Саранцэцэг	магистрант		
8.	Н.Нансалмаа	магистрант	AG20E006@muls.edu.mn	89510001
9.	Д.Мажийсүрэн	магистрант	AG20E004@muls.edu.mn	88611229

10.	Б.Өлзийбаяр	магистрант	ulziibayar750@gmail.com	90890220
-----	-------------	------------	-------------------------	----------

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэр	Албан газар	Албан тушаал	Холбоо барих утас	Zoom, Classroom бүртгүүлэх хаяг
1	А.Мөнгөнцацал	МХЕГ	МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын газрын Үйлдвэр, үйлчилгээний хяналтын хэлтсийн дарга	88083545	munguntsatsal.ao@gmail.com
2	Н.Бямбалхагва	ХАБҮЛЛ,	Чанарын менежер	91193639	b_lkhagva08@yahoo.com
3	Б.Дондов	УХЭШХ	Ургамлын өвчин судлалын лабораторийн эрхлэгч	99243675	dogiibud@yahoo.com
4	Э.Уламбаатар	ХХААХҮЯ	Мэргэжилтэн	99084216	emeel.ulambaatar@yahoo.com
5	Х.Батнаран	УХЭШХ	Шавж судлалын сектрын эрхлэгч	98114621	batnarano@yahoo.com
6	Б.Мөнхцэцэг	УХЭШХ	Эрдэм шинжилгээний ажилтан	99050214	bmuggi9@gmail.com
7	О.Ганбаатар	"Agro Alfa" ХХК	Захирал	99114556	agroalfa576@gmail.com
8	Н.Баярсүх	Дархан, УГТХ	Захирал	99014174 88014174	bayar67@yahoo.com
9	Л.Оюунгэрэл	Дархан, УГТХ	Жимс жимсгэний секторын эрхлэгч	99033594	oyungerel_2000@yahoo.com
10	О.Нинжмаа	Дархан, УГТХ	Секторын эрхлэгч	99024086	ninjma@yahoo.com
11	Д.Насанжаргал	МЖЖҮХ	Тэргүүн	99116339	d.nasanjargal39@gmail.com
12	З.Алтанцэцэг	МХЕГ	Ургамал хамгаалал, ургамлын хорио цээрийн Улсын Ахлах байцаагч	94401100	zul.altans@gmail.com
13	Ш.Оргил	"MGD"ХХК	Захирал	99120056	shorgil0301@gmail.com
14	Т.Дэжидмаа	УХЭШХ	Эрдэм шинжилгээний ажилтан	88721796	dejidmaa.chag@gmail.com
15.	Г.Тэгшбаяр	Агроматко ХХК	ГТ-ийн ахлах менежер	97117131	urusaikome@gmail.com

IV. Төгсөгчдийн нэрс

№	ОВОГ НЭР	АЖЛЫН БАЙР	ЕМАЙЛ	УТАС
1	А.Энхтогтох	"Жино ач" ххк гүйцэтгэх захирал	Enkhtogtokh9911@gmail.com	94118050
2.	Х.Энхтүвшин	УХЭШХ, ЭШДЭДА	Enkhtuwshin.khukhuu@gmail.com	99688067

3.	Д.Дуламжав	Хилийн мэргэжлийн хяналтын газар, байцаагч	Dulamjav0413@gmail.com	98891123
4.	Р.Гандулам	УХЭШХ, ЭШДаА	gandulam91@gmail.com	88054106
5.	М.Гантуяа	УХЭШХ, ЭШ-ний туслах ажилтан	myagmarsaikhangantuya@gmail.com	99145440
6.	Г.Ганчимэг	УХЭШХ, ЭШДэдА	chimgee.gungaa@gmail.com	99868304
7.	Б.Ичинхорлоо	УХЭШХ, ЭШДэдА	b.ichinkhorlooo@yahoo.com	88026398
8.	Т.Батчимэг	УХЭШХ, ЭШДэдА	t.Batchimeg100@gmail.com	88013488
9.	Б.Саруултуяа	НМХГ-ын УХХЦХ-ын улсын байцаагч	<u>Buuveisaruultuya@gmail.com</u>	86688888
10.	Н.Чанцал	АДРА, Олон улсын байгууллага	altan.argai1717@gmail.com	99061055
11.	Б.Оюундарь	БОЯ-ны БХ газар, мэргэжилтэн	oyundari018@gmail.com	88980929
12.	Д.Наранцацралт	УХЭШХ, ЭШТуА	tsatsa12pro@gmail.com	95144736
13.	Н.Отгонбаяр	Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Ургамал хамгаалал, хорио цээр, цацрагийн хяналтын улсын байцаагч.	Otgoonarangua37@gmail.com	88001139

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо,
Зайсан-5, Утас: 34 13 77, Факс: (976-11) 34 17 70,
И-мэйл: info@mul.s.edu.mn, Вэб сайт: www.mul.s.edu.mn

2021.06.21 № 3/231
танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

БОЛОВСРОЛЫН
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Хөдөө аж ахуйн их сургуулийн Магистр, докторын сургуульд харьяалах “Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт, үнэлгээ”-ний магистрын хөтөлбөр нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлагыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээр хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хүргүүлсэн билээ. Үүний дагуу хөндлөнгийн шинжээчийн баг 2021 оны 05 дугаар сарын 28, 31-ний өдрүүдэд өөрийн үнэлгээний багийн гишүүдтэй хамтран ажиллаж, шалгуур бүрийн нотлох баримттай танилцаж ажилласан бөгөөд бидэнд холбогдох тайланг ирүүлсэн байна.

Иймд “Ургамал хамгаалал, хорио цээрийн хяналт, үнэлгээ”-ний магистрын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд тусгасан зөвлөмж, дүгнэлтийг хүлээн авч, цаашид хэрэгжүүлэн ажиллах болно.

Бидэнтэй хамтран ажилласан та бүхэнд баярлалаа.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ
ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ



Г.ГАНТУЛГА